



ЛИБЕРТАРИ НАМ



ҮНДСЭН ДҮРЭМ

(2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан)

(2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан)

(2026.03.04-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан)

ЛИБЕРТАРИ НАМЫГ
ҮҮСГЭН БАЙГУУЛАХ
ИХ ХУРАЛ

2025.09.14



Үүсгэн байгуулах Их хурлын 04 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт баталсан

ЛИБЕРТАРИ НАМЫН ҮНДСЭН ДҮРЭМ

НЭГ. НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ҮНЭТ ЗҮЙЛ, ЗОРИЛГО

- 1.1. Либертари Нам нь хувь хүний эрх чөлөө, хувийн өмч, чөлөөт зах зээл, хязгаарлагдмал төр, нийгмийн консерватизмын үзэл санааг баримталдаг баруун жигүүрийн "палео-либертари" үзэл баримтлалтай улс төрийн байгууллага мөн.
- 1.2. Чөлөөт зах зээлийн тогтолцоонд суурилсан, үндэсний өв уламжлалаа эрхэмлэсэн, гадны улс орнуудтай эв зетэйгээр зэрэгцэн орших нэгэн цогц хөгжлийн бодлогыг Монгол Улсад хэрэгжүүлэх нь Либертари Намын зорилго мөн.
- 1.3. Либертари Нам нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан сахиж хуулийн хүрээнд энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана. Энэхүү дүрэм нь бүлэг, зүйл, заалтаас бүрдэнэ. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/*
- 1.4. Либертари Намын удирдах байгууллага нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.
- 1.5. Либертари Намын үнэт зүйл нь хувь хүний эрх чөлөө, хувийн өмч, чөлөөт зах зээл, хязгаарлагдмал төр, нийгмийн консерватизм.
 - 1.5.1. Хувь хүний эрх чөлөө гэдэг бол хувь хүн өөрийн сонголтоо чөлөөтэй хийх эрх чөлөө төдийгүй тэрхүү сонголтынхоо үр дагаврыг үүрэх хариуцлага. Хувь хүний эрх чөлөө гэдэг нь дур зоргоороо авирлах, бусдын амь нас, эрүүл мэнд, хувийн өмчид халдахын нэр биш.
 - 1.5.2. Хувийн өмч бол чөлөөт нийгмийн үндэс. Хувийн өмч аюулгүй, баталгаатай байх тусам үйлдвэрлэл, худалдаа хөгжин цэцэглэж, ард түмний ахуй амьдрал сайжирдаг. Хувийн өмчийг хуулиар хамгаалаагүй нөхцөлд хүн хөдөлмөрлөх, баялаг бүтээх сэдэлгүй болно.
 - 1.5.3. Үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмчлөл, сайн дурын хамтын ажиллагаа, хөдөлмөрийн хуваарилалтад суурилсан, эдийн засаг дахь төрийн оролцооны түвшнийг нам байлгахыг зорьдог тогтолцоог чөлөөт зах зээлийн эдийн засаг гэнэ.



- 1.5.4. Хувь хүний эрх чөлөө, хувийн өмч, чөлөөт зах зээлийн тогтолцоог хамгаалахаар үүрэг нь хязгаарлагдах төрийг хязгаарлагдмал төр гэнэ. ~~Хязгаарлагдмал төрийн гол 3 институтуци болвоос ард иргэдийг дотоодын хулгайч, луйварчин, дээрэмчин, алуурчдаас хамгаалах "Цагдаагийн газар", гадны түрэмгийлэгчдийг зөгсөөх "Зэвсэгт хүчин", иргэд хоорондын маргааныг шийдэх, хууль ёсыг еажуулах "Шүүх". /Энэ заалтын зарим хэсгийг 2026.03.04-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/~~
- 1.5.5. Улсын язгуур эрх ашгаа эрхэмлэн дээдлэх, үндэсний уламжлал, зан заншил, түүх, соёл, нийгмийн институциудаа сахин хамгаалах нь нийгмийн консерватизмын цөм.
- 1.6. Либертари Нам нь үйл ажиллагаандаа дараах нийтлэг зарчмыг баримтлан ажиллана:
- 1.6.1. Хамтын удирдлага, эв нэгдэл, дотоод ардчилалтай байх зарчмыг баримтална;
- 1.6.2. Намын удирдах байгууллагыг сонгож байгуулах бөгөөд намын бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй, чөлөөт өрсөлдөөний зарчмаар явуулна;
- 1.6.3. Намын бүх шатны байгууллага асуудлыг чөлөөтэй хэлэлцэн олонхын саналаар шийдвэрээ гаргана. Олонхын саналаар шийдвэрээ гаргасан нь цөөнхийн саналаа илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй;
- 1.6.4. Намын бүх шатны байгууллага аливаа шийдвэрийг зохих ёсоор зарласан хуралдаанаар хэлэлцэн гаргах ба аливаа хурлын ирц олонх ирснээр хүчинтэйд тооцогдоно; намын аливаа хуралд гишүүд цахим хэлбэрээр оролцох боломжтой байх, хурлын үйл явцыг тэмдэглэлээс гадна шаардлагатай гэж үзвэл дуу дүрсний бичлэгээр давхар баримтжуулах зэргээр олон нийтэд нээлттэй нам байх зарчмыг барина;
- 1.6.5. Нам нь бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллах, мөн хүйсийн тэгш байдлыг хангаж ажиллахыг зорих бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол намын төлөөллийн төв болон гүйцэтгэх төв байгууллага, хяналтын зөвлөлд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхыг зорино;
- 1.6.6. Намын бүх шатны байгууллага хуралдаанаараа хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргаж, тэмдэглэл хөглөх бөгөөд энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол тогтоолд хуралдаан даргалагч гарын үсэг зурснаар, тэмдэглэлд хуралдаан даргалагч болон хуралдааны нарийн бичгийн дарга гарын зурснаар тус тус хүчин төгөлдөр болно;




- 1.6.7. Намын бүх шатны байгууллагын хурлыг танхимаар болон цахим хэлбэрээр явуулж болно.
- 1.7. Либертари Нам нь Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний эрх ашиг болон намын дүрэмд заасан үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилгод нийцсэн намын мөрийн хөтөлбөртэй байна.

ХОЁР. НАМЫН БҮТЭН БОЛОН ТОВЧИЛСОН НЭР, БЭЛГЭ ТЭМДЭГ, ДАЛБАА

- 2.1. Намын оноосон нэр нь “Либертари Нам” болно. Энэхүү оноосон нэр нь намын бүтэн нэр мөн. Намын нэрийг англиар “Libertarian Party” гэнэ.
- 2.2. Намын бүтэн нэрийг криллээр “ЛН”, латинаар “LP” гэж тус тус товчилж хэрэглэнэ.
- 2.3. Нам нь өөрийн бэлгэ тэмдэг, далбаатай байна.
- 2.4. Намын бэлгэ тэмдэг нь цагаан дэвсгэр дээр баруун гар тал руу дэлгэгдсэн ном байрлах бөгөөд номын дундаас баруун зүгт нисэж буй шар өнгийн шувууны дүрс байрлана. Дэвсгэр цагаан өнгө нь шинэ ирээдүйн цагийг, хар өнгө нь хязгаарлагдмал төр, шар өнгө нь чөлөөт зах зээл, дэлгэгдсэн ном нь үзэл санааг, шувуу нь хувь хүний эрх чөлөөг тус тус бэлгэднэ. Намын бэлгэ тэмдэг дараах байдлаар харагдана. Үүнд:



- 2.5. Намын далбаа нь цагаан, эсхүл шар дэвсгэр бүхий тэгш өнцөгтөөс бүрдэх бөгөөд далбааны өргөн, урт нь 2:1 харьцаатай байна. Намын бэлгэ тэмдэг нь далбааны зах хэсэгт байрлаж, бэлгэ тэмдгийн дэргэд буюу далбааны гол хэсэгт “Либертари Нам” гэж хар өнгөөр бичсэн байна. Намын далбаа нь дараах байдлаар харагдана. Үүнд:



ГУРАВ. НАМЫН ГИШҮҮН, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ, ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХАСАХ, САХИЛГЫН ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ

- 3.1. Нам нь гишүүнчлэлтэй байх бөгөөд намын зорилго, үзэл баримтлал, намын хөтөлбөрийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр намд эвлэлдэн нэгдсэн, 18 нас хүрсэн, эрх зүйн чадамжтай Монгол Улсын иргэн нь намын гишүүнээр элсэж болно.
- 3.2. Намын гишүүн нь намд татвараа төлдөг, намын үйл ажиллагаанд саналын болон сонгох, сонгогдох эрхтэйгээр оролцоно.
- 3.3. Намд гишүүнээр элсэхийг хүссэн иргэн тогтоосон маягтыг биечлэн бөглөнө. Маягтыг биечлэн бөглөх боломжгүй бол намын албан ёсны хаягаар шуудангаар эсвэл намын албан ёсны цахим хуудсаар илгээж болно.
- 3.4. Намын гишүүн нь дараах эрхтэй:
 - 3.4.1. Намын бүтцийн байгууллагын сонгуульд нэр дэвших хүсэлтээ илэрхийлэх, энэ дүрэмд зааснаар сонгуульд өрсөлдөх;
 - 3.4.2. Намын бүтцийн байгууллагын гишүүдийг сонгох;
 - 3.4.3. Намын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;



- 3.4.4. Намын бодлого, үйл ажиллагаа, санхүүжилт, бусад үйл ажиллагаатай холбоотой санал гаргах, хариу авах;
- 3.4.5. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, бодлого боловсруулах, хэлэлцэхэд болон намаас явуулж буй үйл ажиллагаанд оролцох;
- 3.4.6. Намын бүх шатны байгууллагаас өөрийнх нь тухай хэлэлцэхэд биечлэн оролцох, гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд намын бусад эрх бүхий байгууллагад хандах;
- 3.4.7. Намаас гарах, намын гишүүнээс өөрийн хүсэлтээр түдгэлзэх; */Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.4.8. Намд хандив өргөх, өргөсөн хандивынхаа зарцуулалттай танилцах.
- 3.4.9. Намын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох;
- 3.4.10. Намын гишүүний татвараас чөлөөлүүлэх болон хөнгөлүүлэх хүсэлт гаргах, хариу авах. */Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 3.5. Намын гишүүн нь дараах үүрэгтэй:
- 3.5.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, намын үнэт зүйл, үзэл баримтлал, дүрэм, хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон намын бодлогыг хэрэгжүүлэх, намын бусад журам, стандарт, шийдвэрийг даган мөрдөх;
- 3.5.2. Намын гишүүн, дэмжигчдийн хүрээг өргөтгөх, намын байгууллагыг бэхжүүлэхэд идэвх санаачилга гаргах;
- 3.5.3. Намын нэр хүндэд харшлах аливаа хууль бус болон ёс суртахууны нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;
- 3.5.4. Намын бодлого, үнэт зүйл, хөтөлбөрийг сурталчлах, намаас сонгуульд нэр дэвшигчдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- 3.5.5. Намаас нэр дэвшин сонгогдсон болон томилогдсон төрийн улс төрийн албан тушаалтан нь үндэсний эрх ашгийг дээдэлж, хууль болон ёс зүйг чандлан сахиж, ашиг сонирхлын аливаа явцуу бүлэглэлийн нөлөөнд автахгүй байх;
- 3.5.6. Намын нэр хүнд, эв нэгдэл, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх олон нийтэд хандсан үйлдэл хийхгүй байх, намын дотоод мэдээллийг гадагш гаргахгүй байх, намын удирдах эрх бүхий байгууллага, албан тушаалтантай зөвшилцөлгүйгээр дур мэдэн намын өмнөөс үйл ажиллагаа явуулахгүй байх, намын даргын



зөвшөөрөлгүйгээр намын байр суурийг илэрхийлж аливаа мэдэгдэл, мэдээлэл хийхгүй байх;

- 3.5.7. ~~Намын үнэт зүйл, зарчим, бодлого, хотолборийн эсрэг үйл ажиллагаа явуулах, өрөлцөж; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар хассан/~~
- 3.5.8. Намын гишүүний татварыг тогтоосон хугацаанд нь төлөх.
- 3.6. Намын гишүүний үнэмлэх, батламжийн загвар, түүнийг хэрэглэх журмыг Удирдах зөвлөл батална.
- 3.7. Намын гишүүдийн бүртгэлийг Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нийцүүлэн намын Гүйцэтгэх төв байгууллага хөтөлнө.

НАМЫН ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗЭХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

- 3.8. Намын гишүүн өөрийн хүсэлтээр намын гишүүнчлэлээс түдгэлзэх эрхтэй. Хяналтын зөвлөл нь намын гишүүнийг өөрийнх нь хүсэлтээр болон өргөдөл, мэдээлэлд үндэслэн гишүүнээс түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 3.9. Намын гишүүнийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ: */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар бүхэлд нь өөрчлөн найруулсан/*
- 3.9.1. Монгол Улсын Иргэний хуульд заасан эрх зүйн чадамжийг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хязгаарласан;
- 3.9.2. Намын нэр хүндэд харш гэмт хэрэг, зөрчилд холбогдон эрх бүхий байгууллагад шалгагдаж байгаа;
- 3.9.3. Сэтгэцийн өвчнөөр өвчилсөн болох нь эрүүл мэндийн байгууллагын онош, тодорхойлолтоор тогтоогдсон;
- 3.9.4. Сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.
- 3.10. Намын гишүүн өөрийн хүсэлтээр дараах үндэслэлээр түдгэлзэнэ: */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 3.10.1. Эрүүл мэндийн байдлын улмаас тодорхойгүй хугацаагаар намын үйл ажиллагаанд оролцох чадваргүй болсон;
- 3.10.2. Төрийн жинхэнэ алба хаагчаар томилогдсон;



3.10.3. Бусад шалтгаанаар.

3.11. Хяналтын зөвлөл нь намын гишүүнээс өөрийн хүсэлтээр түдгэлзэх хүсэлт болон өргөдөл, мэдээллийн дагуу түдгэлзүүлэх өргөдлийг хүлээн аваад ажлын тав хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв намын гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн бол энэхүү шийдвэрээ гурав хоногийн дотор Гүйцэтгэх зөвлөлд хүргүүлнэ. Гүйцэтгэх зөвлөл нь гишүүнээс түдгэлзүүлсэн шийдвэрийг хүлээн аваад ажлын 3 хоногийн дотор гишүүдийн бүртгэлийн санд түдгэлзүүлсэн төлөвт бүртгэнэ.

*/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*

3.12. Хяналтын зөвлөл нь өөрийн санаачилгаар гишүүнээс түдгэлзүүлэх эсэх асуудлыг хянан шийдвэрлэж болно. */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*

3.13. Энэ дүрмийн 3.9 болон 3.10-д заасан үндэслэлээр намын гишүүнээс түдгэлзсэн хүн тухайн үндэслэл арилсан, дууссан өдрөөс хойш гурав хүртэлх жилийн дотор намын гишүүнчлэлээ сэргээх хүсэлтийг Хяналтын зөвлөлд гаргана. Хяналтын зөвлөл гишүүнчлэлээ сэргээх хүсэлтийг гаргасан өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.

*/Энэ зүйлийг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөн найруулсан/
/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөн найруулсан/*

НАМААС ГАРАХ, НАМЫН ГИШҮҮНЭЭС ХАСАХ

/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

3.14. Намын гишүүн өөрийн хүсэлтээр намаас гарах эрхтэй бөгөөд энэ тухай хүсэлтийг гаргасан өдрөөс хойш ажлын тав хоногийн дотор Хяналтын зөвлөл намын гишүүнчлэлээс чөлөөлнө. Хяналтын зөвлөл гишүүнчлэлээс чөлөөлсөн шийдвэрээ 1 хоногийн дотор Гүйцэтгэх төв байгууллагад хүргүүлнэ. Өөрийн хүсэлтээр гарсан гишүүний мэдээллийг Гүйцэтгэх зөвлөл нь намын гишүүдийн бүртгэлд баяжилт хийж бүртгэнэ.

*/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөн найруулсан/*

3.15. Хяналтын зөвлөл нь дараах үндэслэлээр намын гишүүнээс хасна:

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

3.15.1. намын дүрмийг 3 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн,

3.15.2. намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан.



- 3.16. Намын гишүүнийг энэ дүрмийн 3.15-т заасан үндэслэлээс өөр үндэслэлээр хасахыг хориглоно. /Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 3.17. Намын дүрмийг санаатай зөрчих гэдэг нь мэдсээр байж, зориудаар хүсэж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 3.18. Намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөн гэдэг нь: /Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 3.18.1. Нийгмийн соёл, зан заншил, ёс суртахууны хэм хэмжээ, үнэт зүйлсийг бүгдийг нь ялгахгүй үгүйсгэсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон болох нь баримтаар нотлогдсон;
- 3.18.2. Энэ дүрмийн 4.1-т заасан үндсэн бүтцийн байгууллагын хурал, намын аливаа арга хэмжээнд хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа биелүүлээгүй, тасалсан;
- 3.18.3. Намын хамтын удирдлага, эв нэгдэл, дотоод ардчилалтай байх зарчмыг илтэд эсэргүүцсэн үйл ажиллагаа явуулсан, бусад гишүүдийг үүндээ уриалан дуудсан, татан оролцуулсан, турхирсан,
- 3.18.4. Намын хөрөнгө, орлогоос хувьдаа завшсан, үрэгдүүлсэн болох нь хяналтын зөвлөлийн шийдвэр, аудитын дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн аль нэгээр нь тогтоогдсон;
- 3.18.5. Намд хашдаг албан тушаал, албан үүргийнхээ дагуу олж мэдсэн намын дотоод мэдээллийг зориуд санаатайгаар бусдад задруулсан, хайхрамжгүй байдлын улмаас намын нууцыг агуулж буй баримтыг алдагдах нөхцөлийг үүсгэсэн; намын нууц мэдээллийг задруулсны улмаас намд болоод бусдад эдийн болон эдийн бус хохирол учруулсан;
- 3.18.6. Намын нэр хүндэд харш аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гаргасны улмаас олон нийтийн дунд намын нэр хүндийг унагаасан, сэвтүүлсэн;
- 3.18.7. Энэ дүрмийн 4.1-т заасан намын үндсэн бүтцийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс зориуд санаатайгаар саад учруулж тасалдуулсан, намын хамтын шийдвэр гаргах үйл явцыг түр болон удаан хугацаагаар гацаасан, сарниулсан;
- 3.18.8. Монгол Улсын гадаад улстай тогтоосон найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны эсрэг үйл ажиллагаа явуулахдаа намын нэр, бэлгэ тэмдэг, далбааг ашигласан, мөн эдгээрийг байрлуулсан, агуулсан хувцас эд зүйлийг ашигласан, намын зөвшөөрөлгүйгээр намын нэрийн өмнөөс энэхүү үйл ажиллагааг явуулсан;



- 3.18.9. Намын гишүүний татвараа 3 буюу түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлөөгүй;
- 3.18.10. Намын үнэт зүйл, зарчим, хөтөлбөрийн эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулсан, оролцсон;
- 3.18.11. Энэ дүрмийн 14.6-д заасан үйлдэл, эс үйлдэл;
- 3.19. Хяналтын зөвлөл нь гишүүнийг намаас хасах тухай шийдвэрийг гаргана. Хяналтын зөвлөлийн намаас хассан шийдвэрийг Намын дарга гагцхүү албажуулах үүрэгтэй бөгөөд шийдвэрийг цуцлах, буцаах, албажуулахаас татгалзах эрхгүй. */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.20. Хяналтын зөвлөл сахилгын хэрэг үүсгэх эсэх талаар шалгах ажиллагаа хийлгүйгээр шууд намын гишүүнээс хасах эсэхийг хэлэлцэх, шийдвэрлэхийг хориглоно. Хяналтын зөвлөл нь бусад этгээдээс зөвхөн бичгээр ирүүлсэн гомдол дээр үндэслэн намын гишүүнээс хасах эсэхийг шалган шийдвэрлэнэ.
/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөн найруулсан/

НАМЫН ГИШҮҮНД САХИЛГЫН ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ

- 3.21. Хяналтын зөвлөл нь намын гишүүнд энэ дүрмийн 3.15-д заасан үндэслэлээр сахилгын шийтгэл оногдуулна. */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.22. Намын гишүүнд оногдуулах сахилгын шийтгэл нь дараах төрөлтэй байна. Үүнд: */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.22.1. Нээлттэй болон хаалттай сануулах,
- 3.22.2. Энэ дүрэмд заасан намын гишүүний тодорхой эрхийг 1-6 сар хүртэлх хугацаагаар хасах, хязгаарлах,
- 3.22.3. Намд эрхэлж буй албан тушаалыг бууруулах,
- 3.22.4. Намын дотоод сонгуульд өрсөлдөхийг хориглох,
- 3.22.5. Сонгуульд өрсөлдөх эрхийг түдгэлзүүлэх,
- 3.22.6. Намын гишүүнээс хасах.
- 3.23. Хяналтын зөвлөл нь энэ дүрмийн 3.22-т зааснаас өөр төрлийн шийтгэл оногдуулахыг хориглоно. */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*



- 3.24. Сахилгын шийтгэлийн төрөл, нэр томъёог дараах байдлаар ойлгоно. *Үүнд: /Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.24.1. Хаалттай сануулах гэдэг нь зөрчил гаргасан гишүүнд зөвхөн өөрт нь ганцаарчлан сануулахыг ойлгоно. Олон нийтэд зарлаж сануулахыг нээлттэй сануулах гэнэ,
- 3.24.2. Эрх хязгаарлах гэдэг нь зөрчил гаргасан гишүүнийг 1-6 сар хүртэлх хугацаагаар намын хурал, зөвлөгөөн, арга хэмжээнд оролцуулахыг хориглох,
- 3.24.3. Эрх хасах гэдэг нь зөрчил гаргасан гишүүнийг намын аливаа хурал, зөвлөгөөн дээр санал хэлэх болон санал өгөх эрхийг 1-6 сар хүртэлх хугацаагаар хориглохыг,
- 3.24.4. Албан тушаал бууруулах гэдэг нь зөрчил гаргасан гишүүний намд хашиж байгаа албан тушаалаас буулгахыг, эсхүл намд ямар нэг албан тушаал хашдаггүй боловч тухайн зөрчил гаргасан гишүүний эрхлэн хариуцаж байгаа тодорхой нэг ажил, чиг үүргээс нь чөлөөлөхийг,
- 3.24.5. Дотоод сонгуульд өрсөлдөхийг хориглох гэдэг нь зөрчил гаргасан гишүүнийг намын аливаа албан тушаалд сонгогдохыг 1-6 сар хүртэлх хугацаагаар хойшлуулахыг ойлгоно. Энэ дүрмийн 3.9.2-д заасан үндэслэлээр гишүүнээс түдгэлзэх нь сахилгын шийтгэлд хамаарахгүй болно.
- 3.24.6. Сонгуульд өрсөлдөхийг хориглох гэдэг зөрчил гаргасан гишүүнийг намын нэрийн өмнөөс бүх шатны сонгуульд өрсөлдөхийг хориглохыг,
- 3.24.7. Намын гишүүнээс хасах гэдэг нь зөрчил гаргасан гишүүнийг намаас хөөж, гишүүдийн бүртгэлээс хасахыг ойлгоно.
- 3.25. Хяналтын зөвлөл нь өөрийн санаачилгаар болон бусдаас ирүүлсэн өргөдөл, мэдээлэлд үндэслэн сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг үүсгэх хангалттай үндэслэл, баримт байвал шууд хэрэг үүсгэнэ.
*/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 3.26. Хяналтын зөвлөл нь сахилгын зөрчлийг хянан шалгах явцад цугларсан баримт, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн сахилгын шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэнэ. Сахилгын шийтгэл оногдуулахдаа дараах нөхцөл байдлыг харгалзана. Үүнд: */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.26.1. Гишүүний зөрчил гаргах болсон гол шалтгаан нөхцөлийг харгалзах,



- 3.26.2. Сахилгын зөрчлийн улмаас нам болоод бусдад учруулсан хохирол, хор уршгийн хэмжээ,
- 3.26.3. Намын нэр хүндийг олон нийтийн дунд унагааж, сэвтүүлсэн далайц, үр дагавар.
- 3.27. Хяналтын зөвлөл энэ дүрмийн 3.22-т заасан сахилгын шийтгэлийн төрлийг дараалал харгалзахгүй оногдуулж болно. Сахилгын шийтгэлийн төрлүүдийг дангаар нь болон давхардуулан оногдуулж болно. Давхардуулан сахилгын шийтгэл оногдуулахдаа 2-оос дээш сахилгын шийтгэл давхардуулан оногдуулахыг хориглоно. */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 3.28. Хяналтын зөвлөлийн гишүүн энэ дүрмийн 3.15-д заасан зөрчлийг гаргасан тохиолдолд түүнийг Удирдах зөвлөлөөс хянан шалгаж, энэ дүрмийн 3.22.6-д зааснаас бусад сахилгын шийтгэлийг оногдуулна.
/Энэ зүйлийг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 3.29. Нам нь намын зорилго, үзэл баримтлалыг сайн дурын үндсэн дээр дэмжин намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог дэмжигч иргэдтэй байж болно. */Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- САХИЛГЫН ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА БОЛОН САХИЛГЫН ШИЙТГЭЛГҮЙД ТООЦОХ ХУГАЦАА, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР**
/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 3.30. Энэ дүрэмд заасан сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 жил, зөрчил гаргасан өдрөөс хойш 2 жил өнгөрсөн бол намын гишүүнд сахилгын шийтгэл оногдуулж болохгүй. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 3.31. Хяналтын зөвлөлөөс сахилгын хэрэг үүсгэсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн 3.30-д заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 3.32. Намын гишүүн сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш 6 сарын дотор дахин сахилгын шийтгэл хүлээгээгүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 3.33. Намын гишүүн сахилгын шийтгэлтэй байх хугацаанд намын зүгээс олгох аливаа шагнал, урамшуулал болон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжгүй болно. Мөн сахилгын шийтгэлтэй хугацаанд намын дотоод сонгууль болон бүх шатны сонгуульд нэр дэвших эрхгүй байна. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*



**ДӨРӨВ. НАМЫН УДИРДАХ ДЭЭД БАЙГУУЛЛАГА,
ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, ХУРАЛД ОРОЛЦОХ
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТАЛААР**

- 4.1. Нам нь Удирдах дээд байгууллага, Төлөөллийн төв байгууллага, Гүйцэтгэх төв байгууллага, Хяналтын байгууллага гэсэн үндсэн бүтэцтэй байна.
- 4.2. Намын Их хурал бол намын удирдах дээд байгууллага мөн. /цаашид Их хурал гэх/
- 4.3. Их хурал нь удирдах дээд байгууллага болохын хувьд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
 - 4.3.1. Намын үндсэн дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 4.3.2. Намын даргыг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах;
 - 4.3.3. Төлөөллийн төв байгууллага буюу Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах;
 - 4.3.4. Хяналтын байгууллага буюу Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах;
 - 4.3.5. ~~Гүйцэтгэх төв байгууллага буюу Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох, огцруулах; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар хассан/~~
 - 4.3.6. Намын Удирдах зөвлөл, Гүйцэтгэх зөвлөл, Хяналтын зөвлөлийн тайланг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хэлэлцэх;
 - 4.3.7. Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох;
 - 4.3.8. Намын нэрийг өөрчлөх.
- 4.4. Намын Их хурал нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр төрөлтэй байх бөгөөд түүнд оролцох төлөөлөгчдийн тоо 107 байна.
/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 4.5. Намын ээлжит Их хурал нь дөрвөн жилд нэг удаа хуралдана. Ээлжит их хурлыг анхдугаар Их хурал хуралдсан хугацаанаас хойш тоолно. Удирдах зөвлөл ээлжит Их хурлыг зарлах эрхтэй бөгөөд товыг тогтооно. Их хурал хуралдуулах тухай шийдвэрийг



хуралдах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө гаргана. Их хуралд оролцох төлөөлөгчдийн 50-иас дээш хувь нь оролцож байгаа бол ирцийг хүчинтэйд тооцно.

/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөн найруулсан/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.6. Удирдах зөвлөл намын ээлжит бус Их хурлыг зарлах эрхтэй бөгөөд товыг тогтооно. Ээлжит бус Их хурал хуралдуулах шийдвэрийг хуралдах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө гаргана. Ээлжит бус Их хуралд оролцох төлөөлөгчдийн 50-иас дээш хувь нь оролцож байгаа бол ирцийг хүчинтэйд тооцно. Эхний ээлжит бус Их хурлаас эхлэн хурлыг тоолно. Ээлжит бус Их хурлыг дараах тохиолдолд хуралдуулна. Үүнд:

/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.6.1. Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр шаардсан;

4.6.2. Намын нийт гишүүдийн гуравны нэг шаардсан;

4.6.3. Намын дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

4.7. Ээлжит болон ээлжит бус Их хурлын товыг тогтоосноос хойш ажлын 5 хоногийн дотор намын гишүүдэд цахим шуудангаар болон намын вэбсайт, намын албан ёсны цахим хуудсанд зар байршуулж мэдэгдэнэ.

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн./

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.8. Намын ээлжит болон ээлжит бус Их хурлын төлөөлөгчид дундаасаа 3 хурлын тэргүүлэгч, 2 нарийн бичгийн дарга, 3-аас доошгүй санал тоологчийг сонгох бөгөөд хурлын тэргүүлэгчид дундаасаа хурал даргалагчаа сонгоно. Хурлын даргалагч нь хурлын дэг, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож, хурлын нарийн бичгийн дарга нар нь Их хурлын тэмдэглэлийг бичиж, шийдвэрийн төслийг бэлтгэнэ. Санал тоологчид нь тооллогын комисс буюу хурлын санал хураалтын үр дүнг тоолж, баталгаажуулна.

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөн найруулсан/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.9. Их хурлаар Намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийг сонгохоос бусад асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Их хуралд цөөнх болсон төлөөлөгчдөд байр сууриа илэрхийлж үг хэлэх, дахин санал хураалгах боломжийг хурал даргалагчаас заавал олгоно.

/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

- 4.10. Их хурал энэ дүрмийн 9.1, 10.1-т заасан асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ. /Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 4.11. Их хурал энэ дүрмийн 9.1, 10.1-т зааснаас бусад асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. /Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 4.12. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэн өрсөлдсөн гишүүнийг Их хурлын төлөөлөгчдөөс авсан саналын тооны дарааллаар байр эзлүүлэн жагсаах бөгөөд энэхүү жагсаалтыг Их хурлаас тогтоол гарган баталгаажуулна. Ийнхүү жагсаалтыг баталгаажуулсны үр дагавар нь хожим Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарвал жагсаалтад түүний дараагийн байранд бичигдсэн гишүүнийг нөхөн сонгох үндэслэл болно. Уг жагсаалт нь дараагийн ээлжит болон ээлжит бус их хурал болтол хүчин төгөлдөр байна.
/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн нэмэлт оруулсан/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 4.13. Их хурал энэ дүрмийн 4.12-т заасан жагсаалтаас хамгийн их санал авсан нэр дэвшигчдийг саналын тооны дарааллаар Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнтэй тэнцүү тоогоор тасалбар болгон сонгогдсонд тооцно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 4.14. Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэр дэвшин өрсөлдөөд сонгогдоогүй боловч энэ дүрмийн 4.12-т заасан жагсаалтад нэр нь байгаа гишүүнийг жагсаалтад эзэлсэн дарааллын дагуу тухайн байгууллагад нөхөн сонгогдсонд тооцож Их хурал тогтоол гаргана. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

НАМЫН ИХ ХУРАЛД ТӨЛӨӨЛӨГЧ ОРОЛЦОХ ТУХАЙ

- 4.15. Намын Их хуралд оролцох төлөөлөгчид нь намын жирийн гишүүд болон намын сонгуульт албан тушаалтнаас бүрдэнэ. Их хурлын төлөөлөгчдийн 50 нь намын жирийн гишүүд байх ба харин намын сонгуульт гишүүд 57 байна.
/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 4.16. Дараах сонгуульт албан тушаалтнууд нь Их хуралд шууд төлөөлөгчөөр оролцох эрхтэй бөгөөд заавал хурлын төлөөлөгч байна:
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

v Намын дарга;



- v Удирдах зөвлөлийн гишүүн;
- v Ерөнхий нарийн бичгийн дарга;
- v Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн;
- v Хяналтын зөвлөлийн гишүүн;
- v Аймаг, нийслэлийн намын дарга;
- v Нийслэлийн дүүрэг, хот, тосгоны намын дарга;
- v Монгол Улсын Их Хурлын гишүүн;
- v Намаас төрийн улс төрийн албан тушаалд сонгогдсон болон томилогдсон гишүүн;
- v Намын бодлого судалгааны төвийн тэргүүн болон судлаачид.

4.17. Ээлжит болон ээлжит бус Их хурлын товыг тогтоосноос хойш ажлын 10 хоногийн дотор тухайн аймаг, нийслэл, нийслэлийн дүүрэг, хот, тосгоны намын дарга нарт мэдэгдэнэ.

/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.18. Намын нэгжийн дарга нь намын Их хуралд оролцох боломжгүй бол төлөөлөгч томилж болно. Төлөөлөгч нь тухайн нэгжийн намын гишүүн байна.

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.19. Намын дарга нь ээлжит болон ээлжит бус Их хурлаар хэлэлцэх асуудлыг Их хуралд санал оруулна. Намын дарга бүрэн эрхийн хугацаанаас өмнө огцорсон, чөлөөлөгдсөн, намын гишүүнээс түдгэлзсэн, түдгэлзүүлсэн байгаа тохиолдолд ээлжит болон ээлжит бус Их хурлаар хэлэлцэх асуудлыг Удирдах зөвлөл санал оруулна.

/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

4.20. Энэ дүрмийн 4.16-д зааснаас бусад намын гишүүд ээлжит болон ээлжит бус Их хуралд төлөөлөгчөөр оролцох бол өөрийн нэрийг дэвшүүлж сонгогдоно. Их хурлын төлөөлөгчид нэрээ дэвшүүлэх, сонгох сонгуулийг цахим системээр явуулна. Их хурлын төлөөлөгчид нэр дэвшигчийн авсан саналын тоогоор дараалалд оруулан жагсааж, эхний 50 намын гишүүнээр тасалбар болгон төлөөлөгчөөр сонгогдсонд тооцно.

/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/



- 4.21. Ээлжит болон ээлжит бус Их хурлын аливаа шийдвэр нь хувь хүн болон нийгмийн бүлгийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 4.22. Удирдах зөвлөл, эсхүл түүнээс томилогдсон ажлын хэсэг нь ээлжит болон ээлжит бус Их хуралд нэр дэвшигчдийн 30 хувиас доошгүй нь аль нэг хүйсийн төлөөлөл байх зарчмыг хангаж ажиллана. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 4.23. Их хурлыг зохион байгуулах ажлын хэсэг нь намын эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй гишүүд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангахад онцгойлон анхаарч ажиллана. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 4.24. Их хурлаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх тохиолдолд энэ дүрмийн 9 дүгээр бүлэгт заасан дэлгэрэнгүй журмыг баримтална. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

**ТАВ. НАМЫН ТӨЛӨӨЛЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА,
ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, АЖИЛЛАХ ЖУРАМ**

/Энэ бүлгийн нэрийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

- 5.1. Их хурлын чөлөө цагт Удирдах зөвлөл ажиллах бөгөөд Удирдах зөвлөл нь намын төлөөллийн төв байгууллага мөн. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нь дөрвөн жил байна. /цаашид Удирдах зөвлөл гэх/
- 5.2. Удирдах зөвлөл 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэг жилд дөрвөөс доошгүй удаа хуралдана. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 5.3. Удирдах зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна:
- 5.3.1. Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлох;
- 5.3.2. Бүх шатны сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэж батлах;
- 5.3.3. Бүх шатны сонгуульд нэр дэвших намын гишүүнд эрх олгож, нэр дэвшигчээр батлах
- 5.3.4. Намын Хяналтын Зөвлөлтэй харилцах, энэ дүрэмд заасан асуудлаар дүгнэлт гаргуулах;



- 5.3.5. Намын даргыг огцруулах саналыг Их хуралд гаргах;
- 5.3.6. Ерөнхий нарийн бичгийн дарга болоод Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг сонгох, огцруулах, нөхөн сонгох,
- 5.3.7. ~~Их хурлын чөлөөт цагт Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд орон тоо гарвал нөхөн сонгох; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар хассан/~~
- 5.3.8. Намын анхан болон дунд шатны байгууллагыг байгуулах эсэхийг шийдвэрлэх, хянан шалгах, түүний удирдах бүрэлдэхүүний ажиллах журам, стандартыг тогтоох;
- 5.3.9. Энэ дүрмийн 13.36-д заасан нэгжийг байгуулах эсэхийг шийдвэрлэх, тухайн нэгжийн ажиллах журам, стандартыг батлах; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 5.3.10. Намын дарга болоод Гүйцэтгэх зөвлөлийн хууль, захиргааны хэм хэмжээний акт, энэ дүрэмд нийцээгүй шийдвэрийг хүчингүй болгох;
- 5.3.11. Намын гишүүний татварын хэмжээ, төлөх хуваарийг тогтоох, гишүүний татвартай холбоотой журмыг батлах; намын гишүүний үнэмлэх, батламжийн загварыг батлах, түүнийг хэрэглэх журмыг батлах,
- 5.3.12. Намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 5.3.13. Намын жил бүрийн төсвийг батлах; намаас зохиож буй тодорхой нэг арга хэмжээ, үйл ажиллагааны төсвийг тухай бүрт нь батлах;
- 5.3.14. Их хурлын чөлөөт цагт гишүүдийн дийлэнх олонхын саналаар намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 5.3.15. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг авах эсэх асуудлыг Намын даргын санал болгосноор хэлэлцэх; төрийн санхүүжилтийг хуваарилах; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 5.3.16. Намыг идэвхгүйд тооцсон тухай, хуульд заасан зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, нотлох баримтыг бүрдүүлэн эрх бүхий байгууллагад хүргүүлэх,
- 5.3.17. Намын санхүүгийн тайланг шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг 4 жилийн хугацаатайгаар томилох, уг аудиторыг дахин 4 жилээр улируулан томилох эсэхийг шийдвэрлэх,



- 5.3.18. Намын даргын өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг шийдвэрлэх,
- 5.3.19. Бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг олох, шалгаруулах журмыг батлах,
- 5.3.20. Хяналтын зөвлөлийн гишүүнд сахилгын хэрэг үүсгэх, хянан шалгах, энэ дүрмийн 3.22.6-д зааснаас бусад сахилгын шийтгэлийг оногдуулах, */Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчилсөн/*
- 5.3.21. Намын тамгыг хүлээлцүүлэх ажиллагааг зохион байгуулах,
- 5.3.22. Энэ дүрэмд заасан бусад эрх.
- 5.4. Удирдах зөвлөлийн дарга нь Намын дарга байна. Удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус, өргөтгөсөн бүх хуралдааныг Намын Дарга даргалан явуулна. Хэрэв намын дарга Удирдах зөвлөлийн хуралдаанд ирээгүй тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүд дотроосоо тухайн хурлыг даргалах даргалагчийг сонгоно.
- 5.5. Удирдах зөвлөл нь аливаа шийдвэрийг гаргахдаа хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж, хурлын тэмдэглэл хөтөлнө. Удирдах зөвлөлийн шийдвэр нь тогтоол байна. Удирдах зөвлөлийн хуралд нийт гишүүдийн дийлэнх олонх буюу 8 ба түүнээс дээш гишүүн ирснээр ирц хүчин төгөлдөр болно.
- 5.6. Удирдах зөвлөлийн гишүүдийн ирц энэ дүрмийн 5.5-д заасан тоонд хүрэлгүйгээр хуралдаж гаргасан аливаа шийдвэр нь хүчин төгөлдөр бус байх бөгөөд шаардлагатай бол энэ талаар Хяналтын зөвлөлөөс шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон дүгнэлт гаргана.
- 5.7. Удирдах зөвлөл нь энэ дүрмийн 5.3.5, 5.3.6, 5.3.14, 6.18-д зааснаас бусад асуудлыг хүчин төгөлдөр ирцийн олонх буюу хуралдаанд оролцсон гишүүдийн 50-иас дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.8. Энэ дүрмийн 5.3.5, 5.3.6, 5.3.14, 6.18-д заасан асуудлыг Удирдах зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар буюу 8 ба түүнээс гишүүний саналаар шийдвэрлэнэ.
- 5.9. Удирдах зөвлөлийн тогтоолд тухайн хуралдаанд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурна. Хурлын тэмдэглэлд хэлэлцэж буй асуудлаар гишүүдийн илэрхийлсэн зөрүүтэй байр суурь, хэн дэмжсэн, дэмжээгүй санал өгсөн зэргийг тэмдэглэх тул Удирдах зөвлөлийн гишүүн тогтоолд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй. Хэрэв тогтоолд гарын үсэг зураагүй бол намын үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэж үзэх тул тухайн гишүүнд сахилгын хэрэг үүсгэх шууд үндэслэл болно.
- 5.10. Удирдах зөвлөлийн хуралдааны явцыг заавал хурлын тэмдэглэл хөтөлж баримтжуулна. Хурлын тэмдэглэлд тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн ирц, хурлаар хэлэлцсэн асуудал, гишүүдийн гаргаж байсан санал, байр суурь, санал хураалтын явц, хэлэлцэн



шийдвэрлэсэн асуудлыг дэмжсэн болон дэмжээгүй саналыг хэн гаргасныг тодорхой бичнэ. Хурлын тэмдэглэлд хурал даргалагч, хурлын тэмдэглэлийг хөтөлсөн нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

- 5.11. Удирдах зөвлөлийн хуралдааныг намын Дарга, эсхүл Удирдах зөвлөлийн гишүүдийн олонх, эсхүл Ерөнхий нарийн бичгийн дарга, Хяналтын зөвлөлийн шаардсанаар зарлан хуралдуулна. Удирдах зөвлөлийн аливаа хуралдааны товыг хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө Удирдах зөвлөлийн бүх гишүүдэд боломжит бүх арга хэрэгслээр мэдэгдсэн байна. Хэрэв хурлын товыг Удирдах зөвлөлийн гишүүнд зориуд санаатайгаар мэдэгдээгүй нь тогтоогдвол сахилгын хэрэг үүсгэн шалгах үндэслэл болно. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 5.12. Удирдах зөвлөл нь Гүйцэтгэх зөвлөл, Хяналтын зөвлөл болоод бусад гишүүдийг оролцуулсан өргөтгөсөн хуралдааныг хийж болно. Өргөтгөсөн хуралдаанд Удирдах зөвлөлийн гишүүдээс бусад гишүүд байр сууриа илэрхийлэх, хэлэлцэх асуудлын дараалалд санал оруулах, хуралдааны явцад санал гаргах эрхтэй боловч санал хураалтад саналын эрхгүй оролцоно.
- 5.13. Өргөтгөсөн хуралдааныг дараах тохиолдолд хийж болно. Үүнд:
 - 5.13.1. Бүх шатны сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг батлах,
 - 5.13.2. Намын санхүүгийн болон хөрөнгөтэй холбоотой аливаа асуудал, мөн санхүүгийн тайланг хэлэлцэх,
 - 5.13.3. Бүх шатны сонгуульд бусад намтай эвсэл байгуулах эсэхийг хэлэлцэх,
 - 5.13.4. Намын дотоодод мөрдүүлэх аливаа журам, дүрмийг батлахад,
 - 5.13.5. Бүх шатны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг батлах,
 - 5.13.6. Цаг үеийн бусад асуудлаар.
- 5.14. Удирдах зөвлөлийн гишүүнийг намын Их хурал огцруулна. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*
- 5.15. Удирдах зөвлөлийн гишүүнд дараах зүйлийг хориглоно. Үүнд:
 - 5.15.1. Удирдах зөвлөлийн хуралдааны товыг бусад гишүүдэд зориуд санаатайгаар мэдэгдээгүй, мэдэгдэхээс зайлсхийсэн,
 - 5.15.2. Удирдах зөвлөлийн хуралдааны шийдвэр болон тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзах,



- 5.16. Удирдах зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр хугацаанаас өмнө огцруулж, чөлөөлнө. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 5.16.1. Энэ дүрмийн 3.15, 5.15-д заасан үндэслэлээр огцруулна,
- 5.16.2. Энэ дүрмийн 8.7.1, 8.7.3 -д заасан үндэслэлээр чөлөөлнө.
- 5.17. Удирдах зөвлөлийн гишүүнийг огцруулахад Хяналтын зөвлөлөөр дүгнэлт гаргуулж болно.
- 5.18. Удирдах зөвлөлийн гишүүнийг огцруулах саналыг Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүн аль нь ч Их хуралд гаргаж болно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 5.19. Удирдах зөвлөлийн гишүүн хугацаанаас өмнө огцорсон, чөлөөлөгдсөн тохиолдолд энэ дүрмийн 4.12-т заасан жагсаалтаас түүний дараа бичигдсэн гишүүн нөхөн сонгогдоно. Удирдах зөвлөлийн гишүүн нөхөн сонгогдсон бол бүрэн эрхийн хугацаа нь өмнөх гишүүний хугацаатай адил байна. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 5.20. Удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 40 хувиас доошгүй нь аль нэг хүйсийн хүн байна. Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална.
- 5.21. Нам нь Монгол Улсын Их Хурлын сонгуульд намаас нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороогүй байна.

ДОТООД АУДИТОР

/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

- 5.22. Дотоод аудитор ажиллах этгээдийг намын дарга нэр дэвшүүлж Удирдах зөвлөлөөс 4 жилийн хугацаатайгаар томилно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 5.23. Дотоод аудиторыг томилох эсэх асуудлыг Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв Удирдах зөвлөлөөс дотоод аудитор ажиллах томилохоос татгалзсан бол Намын дарга нь дахин өөр аудиторыг нэр дэвшүүлнэ. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 5.24. Дотоод аудитор нь бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө ажиллах боломжгүй болсон бол намын дарга дараагийн аудиторыг нөхөн нэр дэвшүүлж, удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. Нөхөн томилогдсон дотоод аудиторын бүрэн эрхийн



хугацаа нь өмнөх аудиторын хугацаатай адил байна. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

ЗУРГАА. НАМЫН ГҮЙЦЭТГЭХ ТӨВ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 6.1. Намын гүйцэтгэх төв байгууллага нь Гүйцэтгэх зөвлөл мөн. Гүйцэтгэх зөвлөл нь нийт 5 гишүүнтэй байна. Гүйцэтгэх зөвлөл нь Удирдах зөвлөлийн өмнө ажлаа бүрэн хариуцна. Гүйцэтгэх зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. /цаашид Гүйцэтгэх зөвлөл гэх/
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 6.2. Гүйцэтгэх зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх зөвлөлийн дөрвөн гишүүнээс бүрдэнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Гүйцэтгэх зөвлөлийн тэргүүн байна. Гүйцэтгэх зөвлөл хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бөгөөд шийдвэр нь тогтоол байна. /цаашид Ерөнхий нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн гэх/ */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 6.3. Гүйцэтгэх зөвлөлийг Удирдах зөвлөлөөс нууц санал хураалтаар сонгоно. Гүйцэтгэх зөвлөлийг сонгохдоо дараах журмыг баримтална. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
 - 6.3.1. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд Намын дарга, Удирдах зөвлөлийн гишүүн, Хяналтын зөвлөлийн гишүүнээс бусад намын гишүүн хэн ч нэрээ дэвшүүлэн өрсөлдөх бүрэн эрхтэй. Удирдах зөвлөлийн нийт гишүүдийн дийлэнх олонх буюу 8 гишүүний дэмжсэн саналыг авсан тохиолдолд нэр дэвшигчийг Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно. Гүйцэтгэх зөвлөл дотроосоо Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгоно. */Энэ заалтад 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/*
 - 6.3.2. ~~Удирдах зөвлөлөөс сонгогдсон Ерөнхий нарийн бичгийн дарга нь өөрийн багийг бүрдүүлэх бүрэн эрхтэй тул Гүйцэтгэх зөвлөлийн дөрвөн гишүүний нэрсийг сонгогдсон өдрөөсөө хойш гурав хоногийн дотор Удирдах зөвлөлд санал оруулна. Ерөнхий нарийн бичгийн даргаас бусад этгээд Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч тодруулах, өрсөлдүүлэхийг хориглоно. /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/~~
 - 6.3.3. ~~Удирдах зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн даргаас санал оруулсан Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нарыг хүн тус бүрээр санал хурааж, Удирдах зөвлөлийн нийт гишүүдийн олонх буюу 6 гишүүн дэмжсэн бол нэр дэвшигчийг~~



Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно. /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/

- 6.3.4. Удирдах зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн даргаас санал болгосон дөрвөн нэр дэвшигчээс хүн тус бүр дээр нэг удаа сонгохоос татгалзах эрхтэй. Удирдах зөвлөл нэр дэвшигчийг сонгохоос татгалзсан шийдвэрт сонгохоос татгалзсан үндэслэлийг заавал дурдана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь татгалзагдсан нэр дэвшигчийн нэрийг Удирдах зөвлөлд дахин оруулахыг хориглоно. /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/
- 6.3.5. Удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш гишүүн татгалзах санал гаргасан тохиолдолд Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг татгалзагдсанд тооцно. /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/
- 6.3.6. Удирдах зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн даргын санал оруулсан Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг хоёр дахь удаагаа сонгохоос татгалзах эрхгүй. /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/
- 6.3.7. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд дотроосоо Ерөнхий нарийн бичгийн даргыг олонхын саналаар сонгоно. /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар нэмсэн/
- 6.4. Гүйцэтгэх зөвлөл аливаа шийдвэрээ олонхын саналаар гаргана. Хэрэв Ерөнхий нарийн бичгийн дарга огцорвол дараагийн Ерөнхий нарийн бичгийн дарга сонгогдох хүртэл Гүйцэтгэх зөвлөлийн аль нэг гишүүн түүнийг орлоно. Гүйцэтгэх зөвлөлийн бүх гишүүн хуралдаанд хүрэлцэн ирснээр хурлын ирц хүчинтэй байх бөгөөд хуралдааныг Ерөнхий нарийн бичгийн дарга даргалан явуулна. Гүйцэтгэх зөвлөл нь хуралдахдаа энэ дүрмийн 5.4, 5.9, 5.10 дугаар зүйлд заасан журмыг нэгэн адил мөрдөнө.
/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөн найруулсан/
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 6.5. Ерөнхий нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдэд дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 6.5.1. Их хурал, Удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг биелүүлэхгүй байх, уг бодлого шийдвэрийг эсэргүүцэх, эсрэг үйл ажиллагаа явуулах;
- 6.5.2. Намын даргаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд өгсөн үүрэг чиглэл, зааврыг биелүүлэхгүй байх;
- 6.5.3. Хяналтын зөвлөлийн сонгуульд нэр дэвшигч тодруулах, нэр дэвшүүлэх; хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд санаатайгаар нөлөөлөх;
- 6.5.4. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд саад учруулах; Удирдах зөвлөлийн гишүүнд санаатайгаар нөлөөлөх;



ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

6.6. Гүйцэтгэх зөвлөлийн 5 гишүүн нь намын санхүү, татвар хураалт болон бүртгэл, хандив цуглуулах, хэвлэл мэдээлэл, гишүүдийн бүртгэл, намын архив, намын дотоод харилцаа гэх мэт өдөр тутмын чиг үүргийг хариуцан ажиллана.

/Энэ зүйлд 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан /

/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/

6.7. Гүйцэтгэх зөвлөл нь дараах эрх үүрэгтэй байна. Үүнд:

- 6.7.1. Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг туслалцааг авах эсэх санал, төлөвлөгөөг боловсруулах, улмаар уг санал, төлөвлөгөөг намын даргад танилцуулах,
- 6.7.2. Намын гишүүдийн татвар хураалтыг нэмэгдүүлэх, татварыг хэрхэн үр дүнтэй, бага зардлаар цуглуулах талаарх төлөвлөгөөг хагас бүтэн жилээр боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах; хагас болон бүтэн жилийн татвар төвлөрүүлэлтийн үр дүнг тооцох; татвар төлөлтийн бүртгэл хөтлөх;
- 6.7.3. Хуулиар зөвшөөрсөн хандивыг зөвшөөрөгдсөн этгээдээс авах үйл ажиллагааг хууль, дүрмийн дагуу зохион байгуулах; хандивын тоо хэмжээг тооцож, намын Дарга болоод Удирдах зөвлөлд явц үр дүнг тайлагнах;
- 6.7.4. Намын нэр дээр бүртгэлтэй аливаа хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үнэ цэнийг дээшлүүлэх, дордуулахгүй байх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 6.7.5. Хуулиар зөвшөөрсөн намын бусад орлогыг хэрхэн бүрдүүлэх, нэмэгдүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан ажиллах, санал санаачилга гаргах, энэ талаарх намын Дарга, Удирдах зөвлөл, Их хурлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- 6.7.6. Намын дарга болоод Удирдах зөвлөлөөс өгсөн аливаа үүрэг, чиглэл, зааврыг биелүүлэх, энэ талаарх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үр дүнг заасан хугацаанд тайлагнаж байх;
- 6.7.7. Намын гишүүдийн дундаас бүх шатны сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг олж шалгаруулах ажлыг гардан гүйцэтгэх; заасан хугацаанд нэр дэвшигчдийг танилцуулахад бэлэн болгох, нэр дэвшигчийг Удирдах зөвлөлд танилцуулах;
- 6.7.8. Намын гишүүдийн дундаас бүх шатны сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг олж шалгаруулах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа Удирдах зөвлөлд гаргах;
- 6.7.9. Намын даргаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, энэ талаарх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;



- 6.7.10. Намын гишүүдийн нэгдсэн бүртгэлийг намаас гарсан, татгалзсан, түдгэлзсэн, түдгэлзүүлсэн, хассан төлөвөөр хөтлөх; мөн сахилгын шийтгэл авсан гишүүдийн бүртгэлийг хөтлөх, сахилгын шийтгэлийн хугацаа хэзээ эхэлсэн, хэзээ дуусах зэргээр ангилан хөтлөх, бүртгэлийн өөрчлөлт баяжилтыг тухай бүр нь хийх, */Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан/*
- 6.7.11. Шаардлагатай асуудлаар Хяналтын зөвлөлөөр дүгнэлт гаргуулахаар хандах, дүгнэлт гаргуулах,
- 6.7.12. Намын үндсэн дүрэм болон намын бусад журмын төсөлд саналаа өгөх,
- 6.7.13. Намын архив, албан хэрэг хөтлөлтийг хариуцах; намын санхүүгийн баримтууд болоод шаардлагатай баримтуудыг архивлан хуульд заасан хугацаагаар хадгалах,
- 6.7.14. Намын үнэт зүйл, үзэл баримтлал, зарчим, дүрэм, хөтөлбөрийн талаар намын гишүүдэд зориулсан сургалт зохион байгуулах чиглэлээр Бодлого судалгааны төвтэй хамтран ажиллах; мөн олон нийтэд намын хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг сурталчлан таниулах үйл ажиллагаа явуулах, */Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан/*
- 6.7.15. Хэвлэл мэдээлэл, цахим орчинд намын албан ёсны цахим хаяг, хуудсыг байнга хөтлөх; намын үйл ажиллагааг олон нийтэд боломжтой бүх арга хэрэгслээр байнга сурталчлах,
- 6.7.16. Намын цаашдын төлөвлөгөө үйл ажиллагааны чиглэлээр судалгаа хийх, заасан хугацаанд судалгааг Удирдах зөвлөл болон намын Даргад хүргүүлэх,
- 6.7.17. Бодлого судалгааны төвийн тэргүүн болон судлаачдыг томилох; */Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 6.7.18. Энэ дүрэмд заасан бусад эрх, үүрэг.
- 6.8. Гүйцэтгэх зөвлөл нь ажлын албатай байж болно. Ажлын албыг Ерөнхий нарийн бичгийн дарга шууд удирдана. Ажлын алба нь Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хууль, дүрэмд нийцсэн хууль ёсны шийдвэрийг үл маргах журмаар биелүүлнэ.
- 6.9. Ажлын алба нь Гүйцэтгэх зөвлөлийн өмнө ажлаа хариуцна.
- 6.10. Ерөнхий нарийн бичгийн дарга Ажлын албаны бүтэц, орон тоог боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулна. Ажлын албаны бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд бүтэц орон тооны өөрчлөлтийг Удирдах зөвлөлөөр



хэлэлцүүлэн батлуулна. /Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/

- 6.11. Намын Дарга, Удирдах зөвлөл энэ дүрмээр өөрт эрх олгогдоогүй, мөн өөрсдийн хариуцдаг чиглэлд хамаарахгүй асуудлаар Гүйцэтгэх зөвлөлд үүрэг, чиглэл, заавар өгөхийг хориглоно.
- 6.12. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн нь Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүн байж болохгүй.

ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН БҮРЭН ЭРХ, ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ ОГЦРУУЛАХ, ЧӨЛӨӨЛӨХ

- 6.13. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Гүйцэтгэх зөвлөл болон намын өдөр тутмын үйл ажиллагаа удирдан явуулах бөгөөд дараах эрх, үүрэгтэй байна.
- 6.13.1. Гүйцэтгэх зөвлөлийн дөрвөн гишүүнд нэр дэвшигчийг өлж тодруулах, өөрийн тодруулсан нэр дэвшигчээ сонгуулахаар Удирдах зөвлөлд санал оруулах, /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/
- 6.13.2. Удирдах зөвлөлөөс татгалзагдсан нэр дэвшигчийн оронд өөр нэр дэвшигчийг өлж тодруулах, Удирдах зөвлөлд дахин санал оруулах, /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/
- 6.13.3. Намын дарга болон Удирдах зөвлөл, Их хурлаас гаргасан бодлого, шийдвэр, зорилтыг биелүүлэхээр Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн болоод Ажлын албаны ажилтан, санхүүгийн алба, намын гишүүдэд үүрэг чиглэл, даалгавар, заавар өгөх;
- 6.13.4. Удирдах зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд саналын эрхгүйгээр оролцох, санал тайлбар хэлэх, тодорхой асуудлаар санал хураалт явуулах хүсэлтийг хуралдаан даргалагчид гаргах,
- 6.13.5. Ажлын албаны бүтэц орон тоог боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулах, түүнд өөрчлөлт оруулах саналаа Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах,
- 6.13.6. Кабинетийн зарчмыг баримтлаагүй шалтгаанаар Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг огцруулах саналыг Удирдах зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх. /Энэ заалтад 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/
- 6.13.7. Ерөнхий нягтлан бодогчийг томилуулахаар Гүйцэтгэх зөвлөлд санал болгох; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/



- 6.13.8. Ажлын албаны ажилтанг ажилд авах, ажлаас чөлөөлөх, халах.
- 6.14. Удирдах зөвлөл нь Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг хугацаанаас өмнө дараах үндэслэлээр огцруулж, чөлөөлнө. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 6.14.1. Энэ дүрмийн 3.15, 6.5-д заасан үндэслэлээр огцруулна,
- 6.14.2. Энэ дүрмийн 8.7.1, 8.7.3-д заасан үндэслэлээр чөлөөлнө.
- 6.15. Намын Дарга энэ дүрмийн 6.14-д заасан үндэслэлийн аль нэг нь үүссэн тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг огцруулах саналыг дангаараа Удирдах зөвлөлд оруулан шийдвэрлүүлж болно.
- 6.16. Хяналтын зөвлөлөөс Ерөнхий нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг хууль болон намын дүрэм, журмыг зөрчсөн үндэслэлээр огцруулах саналыг Удирдах зөвлөлд оруулж болно.
- 6.17. Удирдах зөвлөлийн 3-аас доошгүй гишүүд Ерөнхий нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг дүрмийн 6.14.1-д заасан үндэслэлээр огцруулах шаардлагатай хэмээн үзэж нэгдсэн бол Удирдах зөвлөлд огцруулах саналыг оруулна.
- 6.18. Удирдах зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг огцруулах саналыг хүлээж аваад 3 хоногийн дотор хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонх буюу 8 гишүүн огцруулахыг дэмжсэн бол огцорсонд тооцно.
- 6.19. Ерөнхий нарийн бичгийг даргыг огцруулах эсэхийг шийдвэрлэхдээ Удирдах зөвлөл нь нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 6.20. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгосон бол бүрэн эрхийн хугацаа нь өмнөх гишүүний хугацаатай адил байна. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгохдоо энэ дүрмийн 6.3.1-т заасан журмыг баримтална. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*

САНХҮҮГИЙН АЛБА

- 6.21. Намын санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтан нь намын ерөнхий нягтлан бодогч байна. Нам санхүүгийн албатай байж болно. Ерөнхий нягтлан бодогч болон санхүүгийн алба нь ажлын албанд харьяалагдана. Ерөнхий нягтлан бодогчийг Ерөнхий нарийн бичгийн даргын санал болгосноор Гүйцэтгэх зөвлөл сонгоно. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*



- 6.22. Намын ерөнхий нягтлан бодогч нь холбогдох хуульд заасны дагуу ~~намын санхүүг~~ хөтөлж, намын санхүүгийн нэгдсэн тайланг гаргах, санхүүгийн тайланг баталгаажуулахаар холбогдох этгээдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
- 6.23. Намын ерөнхий нягтлан бодогч болон санхүүгийн алба нь намын салбар нэгжийн санхүүгийн тайланг авах, шаардах, нэгтгэх, санхүүгийн зөрчлийг арилгуулна.
- 6.24. Санхүүгийн нэгдсэн тайланг намын төлөөллийн төв байгууллага болон гүйцэтгэх төв байгууллагын өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсний дараа сонгуулийн төв байгууллагад ерөнхий нягтлан бодогч хүргүүлнэ.
- 6.25. Нам өөрийн санхүүгийн нэгдсэн тайланг Аудитын тухай хуульд заасан шаардлага хангасан аудитын хуулийн этгээдээр заавал дүгнэлт гаргуулсны дараа тайлангаа сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ.
- 6.26. Намын санхүүгийн тайланд аудитын дүгнэлт хийх хуулийн этгээдийг төлөөллийн төв байгууллага сонгоно. Дараах этгээдээр аудитын дүгнэлт гаргуулахыг хориглоно. Үүнд:
- 6.26.1. Намд ажил, албан тушаал хашиж байгаа,
- 6.26.2. Намд сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал хашиж байсан.
- 6.27. Намын санхүүгийн тайланг баталгаажуулж намын дарга болон ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурж баталгаажуулна. Ерөнхий нягтлан бодогчийн санхүүгийн тайлан дээр зурсан гарын үсэг нь тайланд агуулагдаж байгаа мэдээлэл үнэн зөв хийгдсэний баталгаа болно.
- 6.28. Намын ерөнхий нягтлан бодогч нь аль нэг аж ахуй нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно. Түүнчлэн намын ерөнхий нягтлан бодогч нь төрийн алба болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд давхар алба хашихыг хориглоно.
- 6.29. Гүйцэтгэх зөвлөлийн нийт гишүүдийн 40 хувиас доошгүй нь аль нэг хүйсийн хүн байна. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

**ДОЛОО. НАМЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ,
ТҮҮНИЙГ БАЙГУУЛАХ БОЛОН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГИШҮҮНИЙГ ОГЦРУУЛАХ, ЧӨЛӨӨЛӨХ**

- 7.1. Нам нь энэ дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, намын дүрмээр зохицуулах дотоод маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан хяналтын



зөвлөлтэй байна. Хяналтын зөвлөл бол намын хяналтын байгууллага мөн. /цаашид
Хяналтын зөвлөл гэх/

7.2. Хяналтын зөвлөлийг намын Их хурлаас 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 4 жилийн хугацаагаар сонгоно. Хяналтын зөвлөл нь даргатай байх бөгөөд даргыг Хяналтын зөвлөл дотроосоо олонхын саналаар сонгоно.

/Энэ зүйлийг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/

7.3. Хяналтын зөвлөл нь дараах төрлийн маргааныг харьяалан шийдвэрлэнэ. Үүнд:

7.3.1. Намын гишүүн нь үндсэн дүрэм болон бусад журмыг зөрчсөн эсэх талаарх маргаан; */Энэ заалтад 2026.03.04-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/*

7.3.2. Нам болон түүний гишүүд хооронд үүссэн маргаан;

7.3.3. Намын дотоод сонгуультай холбоотой маргаан;

7.3.4. Намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой маргаан;

7.3.5. Намын дарга, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх зөвлөл хооронд үүссэн эрх мэдэл хуваарилалт, эрх мэдлийн давхцал, хэн ямар чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан.

7.4. Хяналтын зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй:

7.4.1. Намын дүрэм, журмыг зөрчсөн эсэх талаар намын гишүүнд сахилгын хэрэг үүсгэх, тайлбар авах, баримт цуглуулж шалгах;

7.4.2. Намын дүрэм, журам зөрчигдсөн эсэх талаар Удирдах зөвлөл, Намын Дарга, Гүйцэтгэх зөвлөлд дүгнэлт гаргаж өгөх;

7.4.3. Нам болон түүний гишүүний хооронд үүссэн маргааныг хэрэг нээж хянан шийдвэрлэх;

7.4.4. Намын дотоод сонгуультай холбогдон үүссэн маргааныг хэрэг нээж хянан шийдвэрлэх;

7.4.5. Намын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой үүссэн маргааныг хянан шийдвэрлэх;

7.4.6. Намын гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах, уг шийдвэрээ гишүүдийн бүртгэлд тусгуулахаар Гүйцэтгэх зөвлөлд хүргүүлэх;



- 7.4.7. Намын гишүүнээс гарах, татгалзах, хасах, түдгэлзэх, түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, уг шийдвэрээ албажуулах зорилгоор намын Даргад хүргүүлэх; энэ талаарх бүртгэлийн хөтөлж, уг мэдээллээ Гүйцэтгэх зөвлөлд тогтмол хуваалцаж байх; /Энэ заалтад 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/
- 7.4.8. Намын гишүүнийг бүх шатны сонгуульд нэр дэвших боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;
- 7.4.9. Намын гишүүдийн татвар төлөлт, татварын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих; /Энэ заалтад 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 7.4.10. Намын гишүүн байхаас татгалзсан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- 7.4.11. Намын үндсэн дүрмийн заалтыг хэрэглэх, хэрэгжүүлэхэд тодорхойгүй, ойлгомжгүй байдал үүсвэл Монгол Улсын Үндсэн хууль, ердийн хууль, захиргааны хэм хэмжээний акт болоод намын үнэт зүйл, зарчим, үзэл баримтлалд нийцүүлэн тайлбарлах;
- 7.4.12. Намын дарга, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх зөвлөлийн энэ дүрэмд заасан эрх үүргийн давхардал, эрх мэдлийн хуваарилалттай холбоотой маргааныг шийдвэрлэх, энэ талаар дүгнэлт гаргах;
- 7.4.13. Хуульчийн гэрчилгээтэй этгээдийг гэрээний үндсэн дээр хянан шалгагчаар ажиллуулж эрх зүйн дүгнэлт гаргуулах, уг эрх зүйн дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэглэх, шийдвэрийнхээ үндэслэл болгох;
- 7.4.14. Энэ дүрмийн 8.6.2-д заасны дагуу хянан шалгах ажиллагаа явуулж, дүгнэлт гаргах, уг дүгнэлтээ Их хуралд танилцуулах;
- 7.4.15. Намын үндсэн дүрэм, хөтөлбөр, мөн намын бусад журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал, дүгнэлтээ гаргаж, холбогдох этгээдэд хүргүүлэх;
- 7.4.16. Удирдах зөвлөл нь энэ дүрмийн 5.5-д заасан ирцэд хүрэлгүй хуралдаж гаргасан аливаа шийдвэрийг хүчингүй болгосон дүгнэлтийг гаргах;
- 7.4.17. Хяналтын зөвлөлийн жилийн төсвийг боловсруулах, уг төсвөө Удирдах зөвлөлд танилцуулан батлуулах;
- 7.4.18. Хянан шалгагч ажиллуулах зардлыг боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах;
- 7.4.19. Энэ дүрэмд заасан бусад эрх, үүрэг.



- 7.5. Хяналтын зөвлөл нь хуралдаанаар шийдвэрээ гаргах бөгөөд хуралдааныг хяналтын зөвлөлийн дарга даргална. Хяналтын зөвлөл нь аливаа шийдвэрээ гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 7.6. Хяналтын зөвлөлийн хуралдаан хяналтын зөвлөлийн даргын зарласнаар хуралдах бөгөөд хуралдаанд бүх гишүүд оролцсоноор хүчинтэйд тооцогдоно.
- 7.7. Хяналтын зөвлөл энэ дүрмийн 7.3-т заасан дүгнэлт болон маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шийдвэрийнхээ үндэслэл, түүнийг нотолсон нотолгоог шийдвэртээ заавал бичнэ. Хяналтын зөвлөл шийдвэрлэсэн маргаан бүр дээрээ хавтаст хэрэг бүрдүүлж, арван жилийн хугацаагаар хадгална. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/*
- 7.8. Хяналтын зөвлөлийн гишүүнээр Удирдах зөвлөлийн гишүүн, Намын Дарга, Ерөнхий нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, Бодлого судалгааны төвийн ажилтан, Ажлын албаны ажилтныг сонгохыг хориглоно. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/*
- 7.9. Хяналтын зөвлөлийн гишүүн болон зөвлөлийн үйл ажиллагаанд аливаа этгээд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно. Хэрэв намын гишүүний зүгээс Хяналтын зөвлөлд нөлөөлөхөөр завдсан бол түүнд шууд сахилгын хэрэг үүсгэх үндэслэл болно. Намын гишүүн бус этгээд Хяналтын зөвлөл болон түүний гишүүнд нөлөөлсөн, нөлөөлөхөөр завдсан бол хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 7.10. Энэ дүрмийн 7.14.3-т заасан үндэслэлээр хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн Хяналтын зөвлөлийн гишүүний оронд энэ дүрмийн 4.14-т заасан журмаар нөхөн сонгоно. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа өмнөх гишүүний хугацаатай адил байна. */Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 7.11. Хяналтын зөвлөлийн гишүүнээр 25-аас дээш настай намын гишүүн байх бөгөөд урьд шүүхээс санаатай гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй, нам дотор хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн байна. */Энэ зүйлийг 2026.02.15-ны Удирдах зөвлөлийн өөрчлөлт оруулсан/*
- 7.12. Энэ дүрмийн 7.11-т заасан шалгуурыг хангаагүй нэр дэвшигч нь өөрөө Хяналтын зөвлөлд нэр дэвшүүлэлтээс татгалзах ёстой. Хэрэв нэр дэвшигч нь шалгуурыг хангаагүй болохоо мэдсээр байж зориуд санаатайгаар Хяналтын зөвлөлд сонгогдсон болох нь хожим илэрвэл тухайн гишүүнд сахилгын шийтгэл оногдуулах ба Хяналтын зөвлөлийн гишүүнээс огцруулах үндэслэл болно.
- 7.13. Хяналтын зөвлөлийн гишүүнд дараах зүйлийг хориглоно.



- 7.13.1 Энэ дүрмийн 7.11-д заасан шалгуурыг хангаагүй болохоо мэдсээр байж Хяналтын зөвлөлд өрсөлдсөн, сонгогдсон; эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлсэн;
- 7.13.2. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг ашиглан өөртөө болон бусдад давуу байдал үүсгэсэн;
- 7.13.3. Энэ дүрэмд заасан маргааныг хянан шалгах, шийдвэрлэх явцдаа бусдын нөлөөнд автах; өөрт нь нөлөөлөх гэсэн завдалтын талаар бусдад мэдэгдээгүй, нуусан;
- 7.14. Хяналтын зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараах үндэслэлээр Их хурал огцруулж, чөлөөлнө. /Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 7.14.1. Энэ дүрмийн 3.15, 7.13-т заасан үндэслэлээр огцруулна;
- 7.14.2. Санаатай гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, улмаар шүүхээс ял шийтгэсэн шийдвэр хүчин төгөлдөр болсон;
- 7.14.3. Энэ дүрмийн 8.7.1, 8.7.3-д заасан үндэслэлээр чөлөөлнө.
- 7.15. Энэ дүрмийн 7.14-д зааснаас өөр үндэслэлээр Хяналтын зөвлөлийн гишүүнийг огцруулж, чөлөөлөхийг хатуу хориглоно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 7.16. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа явуулах журам, маргаан хянан шийдвэрлэх журмыг Удирдах зөвлөл батална. Хяналтын зөвлөлийн маргаан хянан шийдвэрлэх журамд маргагч талаас тайлбар авах, нотлох баримт гаргаж өгөх, маргааныг шийдвэрлэх хуралдаанд оролцох, хянан шалгагчийг гэрээний үндсэн дээр ажиллуулах зэргээр шударгаар хянан шийдвэрлүүлэх эрхийн баталгааг хангасан байна. Удирдах зөвлөл нь заавал Хяналтын зөвлөлөөс санал авсны үндсэн дээр маргаан хянан шийдвэрлэх журмыг батална. /Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/
- 7.17. Хяналт зөвлөлийн нийт гишүүдийн 40 хувиас доошгүй нь аль нэг хүйсийн хүн байна. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх зарчмыг баримтална. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 7.18. Хяналтын зөвлөл нь санхүү, эрх зүйн мэдлэг дутагдсан тохиолдолд тухайн маргаан, асуудлыг судлах, хянан шалгах, дүгнэлт гаргуулах зорилгоор гэрээний үндсэн дээр санхүүч, хуульчийг ажиллуулж болно. Хуульч болон санхүүчийг хянан шалгагчаар ажиллуулахдаа холбогдох хуулийн дагуу нууцын баталгааг заавал авна.



- 7.19. Хуульчийг зөвхөн нэг удаагийн маргаан дээр хянан шалгагчаар ажиллуулах эсхүл байнгын хянан шалгагчаар ажиллуулах эсэхийг зөвхөн Хяналтын зөвлөл шийдвэрлэнэ.

**НАЙМ. НАМЫН ДАРГЫГ СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ОГЦРУУЛАХ,
ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА, ЭРХ ХЭМЖЭЭ**

- 8.1. Нам нь нийт гишүүдийг удирдан манлайлах, олон нийтийн дунд намын нэр хүндийг өндөрт өргөх Намын Даргатай байна. Намын тамгыг Намын дарга барина. /цаашид Намын Дарга гэх/ */Энэ хэсэгт 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/*
- 8.2. Намын дарга нь Удирдах зөвлөлийн хуралдааныг даргалан явуулж, Удирдах зөвлөлөөс гаргаж байгаа аливаа бодлогыг чиглүүлнэ. Намын дарга нь ажлаа зөвхөн Их хурлын өмнө хариуцна. Намын дарга нь Удирдах зөвлөлийн гишүүн байна.
- 8.3. Намын даргыг Их хурлаас 4 жилийн хугацаатайгаар сонгоно. Намын дарга нь энэ дүрмийн 8.4.9, 12.10, 13.19, 13.25-д зааснаар өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд болон дангаараа шийдвэрлэх асуудал дээр тушаал гаргаж болно.
*/Энэ зүйлд 2026.03.04-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлд 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 8.4. Намын дарга нь дараах эрх, үүрэгтэй байна:
- 8.4.1. Намын ардчилал, гишүүдийн ойлголцол, эв нэгдлийг хангах;
- 8.4.2. Намыг дотоод, гадаадад төлөөлөх;
- 8.4.3. Ерөнхий нарийн бичгийн даргыг огцруулах, өөрчлөх саналыг Удирдах зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх,
- 8.4.4. Намын Их хурал, Удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг намын байгууллага, гишүүдэд даалгах;
- ~~8.4.5. Намын нэрийн өмнөөс бүх шатны сонгуульд орсолдох гишүүдийг Гүйцэтгэх зөвлөлд санал бэлгөж; /Энэ заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан/~~
- 8.4.6. Гүйцэтгэх зөвлөлөөс боловсруулсан төрөөс санхүүгийн дэмжлэг авах эсэх саналыг Удирдах зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх; */Энэ заалтад 2026.03.04-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/*
- 8.4.7. Бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг олох, шалгаруулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах,



- 8.4.8. Их хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох, уг асуудлаа Их хурлаар хэлэлцүүлэхээр санал оруулах, /Энэ заалтад 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмж өөрчилсөн/
- 8.4.9. Намын санхүүжилтэд шаардлагатай хөрөнгийг олон нийтээс татан босгох үйл ажиллагаанд манлайлал үзүүлж оролцох; хөрөнгө босгох талаар Ерөнхий нарийн бичгийн даргад үүрэг, чиглэл, заавар өгөх,
- 8.4.10. Санхүүгийн нэгдсэн тайланд гарын үсэг зурж баталгаажуулах; дотоод аудиторроор ажиллах этгээдийг сонгон нэр дэвшүүлж, Удирдах зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлэх; /Энэ заалтад 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмж өөрчилсөн/
- 8.4.11. Намын гишүүнийг намаас хассан, түдгэлзүүлсэн зэрэг Хяналтын зөвлөлийн шийдвэрийг албажуулах,
- 8.4.12. Энэ дүрэмд заасан үндэслэлээр намын гишүүний татвараас хөнгөлөх, чөлөөлөх,
- 8.4.13. Энэ дүрэмд заасан бусад эрх.
- 8.5. Намын Даргад дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 8.5.1. Намын санхүүгийн нэгдсэн тайланд гарын үсэг зурж баталгаажуулахаас өөрөөр намын санхүү, төсвийн үйл ажиллагаанд захиран зарцуулах эрхтэйгээр оролцох;
- 8.5.2. Хяналтын зөвлөлийн гишүүнд хэн нэгнийг нэр дэвшүүлэх; хяналтын зөвлөлийн үйл ажиллагаанд санаатайгаар нөлөөлсөн, нөлөөлөхөөр завдсан;
- 8.5.3. Намын Даргын албан тушаал, эрх нөлөөг урвуулан ашиглаж, өөртөө болон бусдад давуу байдал үүсгэсэн;
- 8.5.4. Намын дарга нь аль нэг аж ахуйн нэгж, байгууллагад санхүүтэй холбогдсон ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно; /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 8.5.5. Намын аливаа шийдвэрийг албажуулахаас татгалзах. /Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 8.6. Намын даргыг дараах үндэслэлээр хугацаанаас өмнө Их хурал огцруулна. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 8.6.1. Энэ дүрмийн 3.15-д заасан зөрчил гаргасан бол,



- 8.6.2. Энэ дүрмийн 8.5-д заасан үйлдлийг гаргасан болох нь Хяналтын зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон,
- 8.6.3. Нам сонгуульд амжилт гаргаагүй, эсхүл бүх шатны сонгуульд ялаагүй; намын өмнөх сонгуульд үзүүлсэн үр дүнг дордуулж бууруулсан,
- 8.7. Намын даргыг дараах үндэслэлээр Их хурал чөлөөлнө: */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмж өөрчилсөн/*
- 8.7.1. Өөрөө чөлөөлөгдөх хүсэлт гаргасан,
- 8.7.2. Намын дараагийн дарга сонгогдсон,
- 8.7.3. Эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 8.8. Намын Дарга бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө огцорсон, чөлөөлөгдсөн тохиолдолд Удирдах зөвлөлийн гишүүд дундаасаа намын даргын үүрэг гүйцэтгэгчийг сонгон ажиллуулна. Намын даргын үүрэг гүйцэтгэгч нь шинэ намын дарга сонгогдсоноор үүрэг гүйцэтгэгчээр ажиллах хугацаа дуусна.
- 8.9. Нам Монгол Улсын Их Хурлын сонгуульд ялсан тохиолдолд намын Дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд болно.
- 8.10. Намын даргыг энэ дүрмийн 8.6-д заасан үндэслэлээр хугацаанаас нь өмнө огцруулах саналыг Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлөөс Их хуралд оруулна. Их хурал намын даргыг энэ дүрмийн 4.11-т заасан саналаар огцруулна. Их хуралд Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийг төлөөлөн нэг гишүүн огцруулах үндэслэлийг Их хуралд танилцуулах бөгөөд төлөөлөгчид асуулт асууж болно. Үүний дараа даргалагчаас огцруулах эсэх талаар санал хураалтыг явуулна. */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 8.11. Намын Даргын бүрэн эрхийн хугацаа дууссан бол Их хурлыг зарлан хуралдуулж, шинэ Намын даргыг сонгоно. Намын даргын бүрэн эрхийн хугацаа дуусахад түүний Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа мөн адил дууссан гэж үзнэ. */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 8.12. Намын Даргад намын гишүүн хэн ч нэр дэвшин өрсөлдөх эрхтэй. Их хурлын тов зарлагдсан өдрөөс хойш 10 хоногийн дотор намын даргад нэр дэвшигч нь Гүйцэтгэх зөвлөлд бүртгүүлж, намын даргын сонгууль болох хүртэл өөрийн мөрийн хөтөлбөрийг гишүүдэд сурталчлан таниулах үйл ажиллагааг явуулна. Мөн их хурал хуралдах явцад танхимаас их хурлын төлөөлөгч нь намын даргад нэр дэвшин өрсөлдөж болно. Намын даргыг Их хурлаас нууц санал хураалтаар сонгоно. */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*



- 8.13. Их хурлын даргалагчаас бүх нэр дэвшигчдэд өөрийгөө болон мөрийн хөтөлбөрөө танилцуулах боломжоор хангаж, хугацаа тогтоож өгнө. Намын даргыг энэ дүрмийн 4.11-т заасан саналаар сонгоно. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 8.14. Намын Их хурлын даргалагчаас намын даргад нэр дэвшигчид танилцуулга хийж дууссаны дараа саналын хуудсанд нэр дэвшигчдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар бичиж төлөөлөгчдөөс нууцаар санал хураана. Их хурлын төлөөлөгч нь зөвхөн нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигч намын Дарга болно. Их хурал тэр дариу намын Даргыг сонгогдсонд тооцох тухай шийдвэрийг гаргана. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 8.15. Шинэ сонгогдсон намын дарга нь энэ дүрмийн 8.5.4-т зааснаар урьд эрхэлж байсан ажил, албан тушаалаа хүлээлгэн өгнө. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

ЕС. НАМЫН ДҮРЭМ, МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

- 9.1. Намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг Их хурлаар батална. Их хурлын чөлөөт цагт Удирдах зөвлөл нийт гишүүдийнхээ гуравны хоёроос доошгүй саналыг үндэслэн Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 9.2. Удирдах зөвлөлөөс намын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт нь дүрмийн гуравны нэгээс хэтэрч болохгүй. Удирдах зөвлөл энэ дүрмийн 1.1, 1.2, 1.3, 1.6-д заасан намын үзэл баримтлал, үнэт зүйл, зарчимд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хатуу хориглоно.
- 9.3. Намын үндсэн дүрэм, хөтөлбөрт орох өөрчлөлтийн төслийг намын Дарга нь анхан болон дунд шатны нэгжийн дарга нарт хүргүүлнэ. Нэгжийн дарга нь гишүүдэд танилцуулах ажлыг зохион байгуулна. Үндсэн дүрэм, хөтөлбөрт орох өөрчлөлтийн төслийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор уг өөрчлөлттэй холбоотой намын гишүүдийн санал, хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн Төв намд хүргүүлнэ.
- 9.4. Намын дүрэм, хөтөлбөрт орох өөрчлөлтийн төсөлд анхан болон дунд шатны нэгжийн намын гишүүдээс ирүүлсэн саналыг Гүйцэтгэх зөвлөл нэгтгэх ажлыг зохион байгуулна. Ийнхүү нэгтгэсэн саналуудыг Удирдах зөвлөлийн хуралд танилцуулна.
- 9.5. Удирдах зөвлөл нь намын дүрэм, хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө заавал Хяналтын зөвлөлөөс санал, дүгнэлтийг авна.
- 9.6. Холбогдох хууль хүчингүй болсон, эсхүл холбогдох хуулийн заалтад өөрчлөлт орсонтой холбоотойгоор намын үндсэн дүрэм, бусад журмын заалтыг хэрэгжүүлэх боломжгүй болвол тухайн заалтыг хууль хүчингүй болсон болон өөрчлөлт орсон өдрөөр хүчингүйд тооцно.



- 9.7. Удирдах зөвлөл нь энэ дүрмийн 9.3, 9.5-д заасан хэлэлцүүлэг, санал, дүгнэлт авах ажиллагааны аль нэгийг явуулалгүйгээр оруулсан үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт хүчингүй байна. Энэ зүйлд заасан нэмэлт, өөрчлөлтийг Хяналтын зөвлөлийн шийдвэрээр хүчингүй болгоно.
- 9.8. Үндсэн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Намын дарга, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх зөвлөл, Хяналтын зөвлөл гаргах эрхтэй. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 9.9. Намын их хурал хуралдах явцад төлөөлөгчөөс Үндсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тодорхой санал гаргах эрхтэй. Их хурал даргалагчаас тухайн гишүүний гаргаж байгаа дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналын томъёоллыг тодорхой болгоно. Төлөөлөгчөөс гаргаж буй саналын томъёоллыг тодорхой болгосны дараа хурал даргалагчаас уг нэмэлт, өөрчлөлтийн саналыг Их хурлаар хэлэлцэх эсэхийг ил санал хураалтаар шийдвэрлүүлнэ. Намын Их хуралд оролцож байгаа төлөөлөгчдийн олонхын санал авбал тухайн нэмэлт, өөрчлөлтийн саналыг хэлэлцэхийг дэмжсэнд тооцож, Их хурал үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Их хурал нь төлөөлөгчөөс гаргасан үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн саналыг хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн дийлэнх олонхын саналаар батална. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

**АРАВ. НАМЫГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ,
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООХ, ТАРААХ, ТАТАН БУУЛГАХ,
ИДЭВХГҮЙД ТООЦСОН ТОХИОЛДОЛД АЖИЛЛАХ ЖУРАМ**

- 10.1. Нам нийлэх, нэгдэх замаар өөрчлөн байгуулагдах, үйл ажиллагааг зогсоох буюу татан буулгах эсэхийг гагцхүү Их хурлаар шийдвэрлэнэ. Зөвхөн Удирдах зөвлөл нам нийлэх, нэгдэх саналыг болон төслийг Их хуралд оруулна. Нам нийлэх, нэгдэх төслийг энэ дүрмийн 4.10-т заасан журмаар хэлэлцэнэ. /Энэ хэсэгт 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/
- 10.2. Намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарсан тохиолдолд ажлын 10 өдрийн дотор Улсын дээд шүүхэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.
- 10.3. Нам нь өөр намтай нийлсэн тохиолдолд намуудын эрх, үүрэг, хариуцлага, эд хөрөнгө нь нийлэх замаар өөрчлөн байгуулагдсан шинэ намд шилжих тул хуульд заасны дагуу шинээр бүртгүүлнэ.
- 10.4. Нам нь бусад намтай нийлэх замаар өөрчлөгдөн байгуулагдаж байгаа тохиолдолд цаашид аль намын нэрийг ашиглахыг Их хурлаар шийдвэрлэнэ.



- 10.5. Нам нь бусад намтай нийлэх замаар өөрчлөгдөн байгуулагдаж байгаа тохиолдолд намуудаас хамгийн эхэнд байгуулагдсан намын өдрөөр төлөөлүүлэн намын үүсгэн байгуулагдсан өдөр гэж тодорхойлно.
- 10.6. Хэрэв бусад намын зүгээс өөрийн үйл ажиллагааг зогсоож нэгдэх тохиолдолд тухайн нэгдэж байгаа намын эрх, үүрэг, хариуцлага, намын гишүүдийн харьяалал, эд хөрөнгийг өөртөө нэгтгэн авна.
- 10.7. Нам нь бусад намтай нэгдэн нийлэх замаар өөрчлөгдөн байгуулагдаж байгааг үл зөвшөөрч буй намын гишүүн цаашид намын аливаа хөрөнгийг өмчлөх, үргэлжлүүлэн хэрэглэхийг хориглоно.
- 10.8. Хуульд өөрөөр заагаагүй бол намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрт уг ажлыг хариуцах татан буулгах комиссыг 5-аас ихгүй гишүүнтэйгээр байгуулна. Татан буулгах комисс нь нэн тэргүүнд намын өр төлбөрийг барагдуулж дуусгах бөгөөд хэрэв намын хөрөнгө үлдвэл сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ.
- 10.9. Хуульд өөрөөр заагаагүй бол ажлын хэсгээс намын үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг Улсын Дээд шүүхэд хүргүүлж, Улсын Дээд шүүхээс намыг улсын бүртгэлээс хасаж, нийтэд мэдээлэх ба энэ тохиолдолд намын хөрөнгийг түүний хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 10.10. Хуульд өөрөөр заагаагүй бол намыг өөрчлөн байгуулах шийдвэрийг Улсын Дээд шүүхэд мэдэгдэж, холбогдох бүртгэлийг хийлгэх ба энэ тохиолдолд ажлын хэсэг энэ тухай нийтэд мэдээлнэ.
- 10.11. Дээд шүүхээс намыг идэвхгүйд тооцсон тохиолдолд Удирдах зөвлөл нь Улс төрийн намын тухай хуулийн 21.1-т заасан зөрчлийг арилгах шийдвэр гаргаж, улмаар зөрчлийг арилгасан тухай нотлох баримтыг бүрдүүлж, Сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх ажлыг хариуцна.
- 10.12. Улс төрийн намын тухай хуулийн 25.3-т зааснаар Улсын Дээд шүүхээс холбогдох шийдвэр гарснаар намыг тарсанд тооцогдоно.

**АРВАН НЭГ. НАМЫН ГИШҮҮНИЙГ СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЭХ,
ШИЛЖ СОНГОХ, ШАЛГАРУУЛАХ, ЭРХ ОЛГОХ**

- 11.1. Намын нэрийн өмнөөс бүх шатны сонгуульд нэр дэвших эрхийг гагцхүү Удирдах зөвлөлөөс намын гишүүнд олгоно.
- 11.2. Намын гишүүд дундаас бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг хэрхэн олох, шалгаруулах, нэр дэвших эрх олгох эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх талаарх нарийвчилсан журмыг Удирдах зөвлөл батална.
- 11.3. Энэ дүрмийн 11.2-д заасан журамд дараах зүйлийг заавал тусгана. Үүнд:



- 11.3.1. Нэр дэвшигчийг олох: Тухайлбал сонгуульд намаас нэр дэвшигч гишүүн нь намын үнэт зүйл, үзэл баримтлалыг хатуу бөгөөд тууштай хэрэгжүүлдэг байх буюу нэр дэвшигчийн шалгуурын талаар,
- 11.3.2. Нэр дэвшигчийг шалгаруулах: Тухайлбал нэр дэвшигчдийг уралдаант, эсхүл гүйцэтгэлийн, мэтгэлцээний, онооны, намд элссэн хугацааны гэх мэт өрсөлдүүлэх арга, зарчмыг талаар,
- 11.3.3. Нэр дэвших эрх олгох: Нэр дэвшигчийг Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх дараалал, танилцуулгыг хэн хэрхэн хийх, нэр дэвшигчээс асуулт асуух, хариулт өгөх, хэрхэн зөвлөлдөж шийдвэр гаргах зэргээр дэгийг процессжуулан бичсэн байх;
- 11.3.4. Жендэрийн тэгш байдлыг хангах: Аль нэг хүйсийн төлөөлөл 40-өөс багагүй байлгах, нэр дэвшигчийг сонгох, томилох, албан тушаалаас чөлөөлөхөд жендэрийн тэгш байдлыг харгалзаж, хуулийн болзол шаардлагыг заавал хангаж байх, */Энэ заалтад 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт оруулсан/*
- 11.3.5. Төрийн албанд томилох: Намаас төрийн улсын төрийн албанд намын гишүүнийг томилохдоо баримтлах шалгуур, үзүүлэлт болоод намаас баримтлах бодлого, зарчмыг нарийвчлан журамлах,
- 11.3.6. Сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээсээ барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, авахыг хориглох. */Энэ заалтыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 11.4. Удирдах зөвлөл нь 11.2-т заасан журмын төслийг хэлэлцэхдээ тухайн төслийн аливаа заалтыг өөрчлөх, нэмэх, хасах, өөрчлөн найруулах байдлаар батлах бүрэн эрхтэй.
- 11.5. Энэ дүрмийн 11.2-т заасан журмыг хэрэгжүүлэх буюу нэр дэвшигчийг олох, шалгаруулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна. Ерөнхий нарийн бичгийн дарга нь дүрмийн 11.2-т заасан журмыг чанд сахих бөгөөд нэр дэвшигч гишүүдийг Удирдах зөвлөлд оруулж, нэр дэвшигч бүрийн танилцуулгыг хийх байдлаар хэлэлцүүлнэ.
- 11.6. Энэ дүрмийн 11.2-т заасан журмаар сонгогдсон гишүүнийг сонгуульд нэр дэвших боломжтой эсэх талаар намын Хяналтын зөвлөлөөс урьдчилан дүгнэлт гаргана.
- 11.7. Удирдах зөвлөлөөс энэ дүрмийн 11.2-т заасан журам, 11.6-д заасан дүгнэлтээр тухайн гишүүнийг сонгуульд нэр дэвших эрх олгосон тохиолдолд нэр дэвшигчдийг холбогдох байгууллагад бүртгүүлэх ажлыг Гүйцэтгэх зөвлөл хариуцан зохион байгуулна.

**АРВАН ХОЁР. НАМЫН САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР,
НАМЫН ХӨРӨНГИЙН БАЙДАЛ,**



ТҮҮНИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

- 12.1. Намын орлого нь гишүүдийн татвар, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өргөсөн хандив, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, намын бэлгэдэл бүхий бэлэг дурсгалын зүйлс, намын өмчлөлд байгаа хөрөнгө, намын хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны болон хуулиар зөвшөөрсөн бусад орлогоос бүрдэнэ.
- 12.2. Намын гишүүний нэг сарын татварын хэмжээ 7,000 төгрөг буюу нэг жилийн 84,000 төгрөг байна. Намын гишүүн зөвхөн өөрийн орлогоос татвараа төлнө. Намын гишүүн татвараа жил бүрийн эхний улиралд багтаан бэлэн бус хэлбэрээр төлнө. Намын гишүүний нэг сарын татварын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5 хувиас хэтэрч болохгүй. */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан/*
- 12.3. Удирдах зөвлөлийн гишүүний нэг сарын татварын хэмжээ нь 420,000 төгрөг буюу нэг жилийн 5,040,000 төгрөг байна. Удирдах зөвлөлийн гишүүн жил бүрийн эхний улиралд багтаан татвараа бүтэн жилээр тооцож төлнө. Гүйцэтгэх зөвлөл болон Хяналтын зөвлөл гишүүний нэг сарын татварын хэмжээ 210,000 төгрөг буюу нэг жилийн 2,520,000 төгрөг байна. Гүйцэтгэх зөвлөл болон Хяналтын зөвлөлийн гишүүн нэг жилийн татвараа хагас жилээр хоёр хувааж төлөх бөгөөд ийнхүү төлөхдөө тухайн хагас жилийн эхний хоёр сард багтаан төлнө. */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 12.4. Удирдах зөвлөл нь хуульд заасан хэмжээний дотор намын сонгуульт болон жирийн гишүүний татварын хэмжээг тогтооно. Намын гишүүн бусад гишүүний өмнөөс гишүүний татвар төлөхийг хориглоно. Намын гишүүн 3 ба түүнээс дээш сараар татвараа төлөөгүй бол түүнд сахилгын хэрэг үүсгэж, сахилгын шийтгэл ноогдуулах үндэслэл болно. */Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 12.5. Намын хөрөнгийн зарцуулалтын талаар ерөнхий нягтлан бодогч нь хагас жил тутам Удирдах зөвлөл, хяналтын зөвлөлд тайлагнана. Гүйцэтгэх зөвлөл нь гишүүний татвар төлсөн баримтыг 10 жилээс доошгүй хугацаанд архивлан хадгална. */Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 12.6. Гишүүний татвар нь намын өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн гол эх үүсвэр мөн бөгөөд намын бүх гишүүний татварыг намын дансанд байршуулна. */Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 12.7. Намын гишүүний татварын хэмжээг Удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээнээс бууруулан хөнгөлөх, эсхүл татвар төлөхөөс гишүүнийг чөлөөлөх, татварын оронд бараа оролцуулах, ажил гүйцэтгүүлэх зэргийг Удирдах зөвлөлөөс баталсан нарийвчилсан дэлгэрэнгүй журмаар зохицуулна. */Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Элжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*



- 12.8. Намын гишүүн энэ дүрмийн 3.10-т заасан үндэслэлээр намын гишүүнээс түдгэлзсэн тохиолдолд татвар төлөхөөс чөлөөлөгдөнө. Мөн 70-аас дээш настай намын гишүүн татвар төлөхөөс чөлөөлөгдөнө. Энэ дүрмийн 3.9.2-т заасан үндэслэлээр намын гишүүнээс түдгэлзүүлсэн бол татвараас чөлөөлөгдөхгүй. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 12.9. Хөгжлийн бэрхшээлтэй намын гишүүнийг намд төлөх татвараас 50 хувь хөнгөлнө. Мөн намын гишүүн гадаад улсад суралцах, ажиллахаар болсон, эсхүл бага насны хүүхэд болон хүнд өвчтэй гэр бүлийн гишүүн, хамаатан саданг 6 сараас илүү хугацаагаар асрах шалтгааны улмаас хүсэлт гаргасан тохиолдолд намд төлөх татварыг 50 хүртэл хувиар хөнгөлж болно. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 12.10. Энэ дүрмийн 12.8, 12.9-д зааснаар намд төлөх татвараас чөлөөлөх, хөнгөлөх шийдвэрийг Намын дарга гаргана. Намын даргын татвараас хөнгөлж, чөлөөлөх шийдвэрт Хяналтын зөвлөл хяналт тавьж ажиллана. Намын гишүүнийг татвараас хөнгөлж, чөлөөлсөн үндэслэл хожим худал болох нь тогтоогдвол татварыг нөхөн төлүүлнэ. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 12.11. Намын гишүүдээс татвар хураах, татвар төлөлтийн бүртгэл хөтлөх үйл ажиллагааг Гүйцэтгэх зөвлөл хариуцна. Гүйцэтгэх зөвлөлийн татварын бүрдүүлэлт, татварын бүртгэлийн үйл ажиллагаанд Хяналтын зөвлөл хяналт тавина.
- /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
/Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.12. Нам нь хандивыг мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэйгээр авна. Мөнгөн бус хандив гэдэг нь дараах зүйлийг нь үнэ төлбөргүйгээр, эсхүл зах зээлийн дундаж ханшаас доогуур үнээр хийгдэж байгаа тохиолдлыг ойлгоно. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.12.1. хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус баялгийг ашиглуулах, эзэмшүүлэх;
- 12.12.2. үйлчилгээ үзүүлэх;
- 12.12.3. төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх;
- 12.12.4. арга хэмжээний зардлыг төлөх;
- 12.12.5. ивээн тэтгэх.
- 12.13. Намын бусдаас авах хандивын хэмжээ нь дараах хэмжээнээс хэтэрч болохгүй. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 12.13.1. Хандивыг нэг жилд нэг иргэнээс авах дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.



- 12.13.2. Хандивыг нэг жилд нэг хуулийн этгээдээс авах дээд хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэн үнийн дүнгээс илүү байхыг хориглоно.
- 12.14. Нам дараах этгээдээс шууд болон шууд бусаар хандив авахыг хориглоно. */Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 12.14.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн,
- 12.14.2. Гадаад улс буюу гадаад улсын төрийн байгууллага, нам, хуулийн этгээд, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж,
- 12.14.3. Төрийн байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллага,
- 12.14.4. Үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо,
- 12.14.5. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж, тэдгээрийн захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга,
- 12.14.6. Арван найман насанд хүрээгүй Монгол Улсын иргэн,
- 12.14.7. Байгуулагдаад 1 жил болоогүй хуулийн этгээд,
- 12.14.8. Тодорхой нэр, хаяггүй этгээд, эсхүл нэр нь тодорхойгүй гуравдагч этгээдийн хандивыг дамжуулж байгаа этгээд,
- 12.14.9. Өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох зорилгоор хандив өгч байгаа этгээд,
- 12.14.10. Бусад иргэн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс мөнгөн болон мөнгөн бус хандивыг намд өгч байгаа иргэн, хуулийн этгээд,
- 12.14.11. Дампуурсан хуулийн этгээд,
- 12.14.12. Уул уурхайн, ашигт малтмалын олборлолт, боловсруулах салбарын хуулийн этгээд,
- 12.14.13. Хуулиар хориглосон бусад этгээд
- 12.15. Намын бүх шатны байгууллага намын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор хөрөнгө, хандив хуримтлуулах ажлыг зохион байгуулж болох бөгөөд аливаа хандив нь зөвхөн сайн дурынх байна. Намд хандив өргөсөн нь намаас хариу нэхэх үндэслэл болохгүй. */Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*
- 12.16. Хандив өгсөн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэгдсэн тайланг намын ерөнхий нягтлан бодогч жил бүр нэгтгэн гаргаж Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд танилцуулж, эхээр нь хадгална. */Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/*



- 12.17. Намын аливаа баримт бичгийг хариуцсан нэгж, албан тушаалтан нь 10 жилийн хугацаанд эх хувь болон цахимаар хадгална. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.18. Нам нь энэ дүрмийн 12.1-т заасан орлогыг төвлөрүүлэх банкны нэг л данстай байх бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.19. Нам нь энэ дүрмийн 12.1-т заасан орлогыг цахим мөнгөөр хүлээн авахыг хориглоно. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.20. Намын орлогыг зөвхөн намын мөрийн хөтөлбөр, дүрэмд тусгагдсан үйл ажиллагаа явуулахад зарцуулна. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.21. Намын орлогыг өөр зүйлд зарцуулах, гишүүдэд ногдол ашиг болгон хуваарилахыг хориглоно. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.22. Намын үйл ажиллагаанд орлогыг зарцуулахдаа зорилтот үр дүнд хүрэх хамгийн хэмнэлттэй хувилбарыг сонгох зарчмыг баримтална. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/
- 12.23. Намын санхүүгийн тайланг Улс төрийн намын тухай хуулийн 36, 37 дугаар зүйлд заасныг баримтлан намын санхүүгийн удирдах ажилтан хариуцан гаргана. /Энэ хэсгийн дугаарыг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙГ ХУВААРИЛАХ БОЛОН ЗАРЦУУЛАХ

/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

- 12.24. Удирдах зөвлөл нь төрөөс жил бүр олгох санхүүгийн дэмжлэгийг намын салбар болон бүтцийн нэгжид хуваарилах эсэхийг шийдвэрлэнэ. Удирдах зөвлөл нь намын Бодлого судалгааны төвд энэ дүрмийн 12.26.1, 12.26.2, 12.26.3 заалтад заасан санхүүжилтийг заавал олгох бөгөөд санхүүжилт олгохоос татгалзах эрхгүй. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 12.25. Удирдах зөвлөл нь намын салбар, бүтцийн нэгжид санхүүжилтийг хуваарилахдаа тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөний цар хүрээг харгалзан санхүүжилтийн хувь хэмжээг тогтооно. Түүнчлэн тухайн салбар, нэгжийн өмнөх жилийн ажлын



төлөвлөгөөний биелэлтийг шалгуур үзүүлэлт болгон санхүүжилт олгох зэргийг шийдвэрлэж болно. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

12.26. Удирдах зөвлөл нь төрөөс жил бүр олгох санхүүжилтийг дараах хувь хэмжээгээр хуваарилна.

/Энэ зүйлийг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөн найруулсан/

/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

12.26.1. төрийн санхүүжилтийн 20-оос доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;

12.26.2. төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;

12.26.3. төрийн санхүүжилтийн 15-аас доошгүй хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх;

12.26.4. төрийн санхүүжилтийн 18-аас доошгүй хувийг Гүйцэтгэх зөвлөлд;

12.26.5. төрийн санхүүжилтийн 8-аас доошгүй хувийг Удирдах зөвлөлд;

12.26.6. төрийн санхүүжилтийн 8-аас доошгүй хувийг Хяналтын зөвлөлд;

12.26.7. төрийн санхүүжилтийн 16-аас доошгүй хувийг намын анхан болон дунд шатны нэгжид;

~~12.27. Намын Бодлого судалгааны төв нь энэ дүрмийн 12.26.1-д заасан өөрт нөөгдөх санхүүжилтийг дараах зориулалт болон хувь хэмжээгээр зарцуулна. /Энэ хэсгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/~~

~~12.27.1. Хорин хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих, сургаж бэлтгэх;~~

~~12.27.2. Арван таван хувийг намын гишүүдийн болон иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, ардчилал, хүний эрхийн үнэт зүйлийг нийтэд таниулах;~~

~~12.27.3. Арван таван хувийг намын хөтөлбөр, бодлого боловсруулахад чиглэсэн судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, намын дотоод ардчиллыг хөгжүүлэх.~~

/Энэ зүйл, заалтыг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар хассан /

12.28. Энэ дүрмийн 12.26.1, 12.26.2, 12.26.3-д заасан зорилтот санхүүжилт тус бүрийн гуравны нэгээс доошгүйг намын Бодлого судалгааны төв нь өөрийн үйл ажиллагаанд зарцуулна.



*/Энэ зүйлд 2026.03.04-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*

- 12.29. Энэ дүрмийн 12.26-д заасан төрийн санхүүжилтийг тухайн зорилгоос өөр зориулалтаар зарцуулахыг хориглох бөгөөд Хяналтын зөвлөл үүнд хяналт тавина.
*/Энэ зүйлийг 2026.02.15-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар өөрчлөлт оруулсан/
/Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 12.30. Гүйцэтгэх зөвлөл, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, намын анхан болон дунд шатны нэгж нь энэ дүрмийн 12.26.4, 12.26.5, 12.26.6, 12.26.7-д заасан өөрт ноогдох төрийн санхүүжилтийг тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд заасны дагуу зарцуулна. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 12.31. Намд анхан болон дунд шатны нэгж байгуулагдаагүй байгаа тохиолдолд энэ дүрмийн 12.26.7-д заасан санхүүжилтийг хэрхэн хуваарилахыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 12.32. Нам нь сонгуульд нэр дэвших эрх олгохдоо намын гишүүн, дэмжигчээс барьцаа, дэнчин болон бусад аливаа хэлбэрээр мөнгө болон мөнгөн бус хөрөнгө, үйлчилгээ өгөхийг шаардах, мөн авахыг хориглоно. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*

**АРВАН ГУРАВ. НАМЫН САЛБАР БОЛОН БҮТЦИЙН НЭГЖИЙГ БАЙГУУЛАХ,
ТАТАН БУУЛГАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ**

/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар өөрчилсөн/

- 13.1. Нам нь Нийслэл Улаанбаатар хотод байнга байрлаж, үйл ажиллагаагаа Монгол Улсын хэмжээнд явуулах бөгөөд Төв нам гэж нэрлэнэ.
- 13.2. Төв нам гэдэгт
- Удирдах дээд байгууллага буюу намын Их хурал,
 - Төлөөллийн төв байгууллага Удирдах зөвлөл,
 - Гүйцэтгэх төв байгууллага буюу Гүйцэтгэх зөвлөл,
 - Намын дарга,
 - Хяналтын байгууллага буюу Хяналтын зөвлөлийг хамтад нь ойлгоно.
- 13.3. Нам нь анхан шатны нэгжийг дараах бүтэцтэйгээр байгуулж болно. Үүнд:
- 13.3.1. аймгийн намын анхан шатны нэгж,
- 13.3.2. нийслэлийн дүүрэг дэх намын анхан шатны нэгж,
- 13.3.3. улсын зэрэглэлтэй хотын намын анхан шатны нэгж,



- 13.3.4. тосгоны намын анхан шатны нэгж.
- 13.4. Нам нь дунд шатны нэгжийг дараах бүтэцтэйгээр байгуулж болно. Үүнд:
- 13.4.1. Нийслэлийн намын нэгж.
- 13.5. Нийслэлийн намын нэгж нь анхан шатны нэгжийг удирдлагаар хангаж, мөн Төв намыг анхан шатны нэгжтэй холбох үүргийг гүйцэтгэнэ.
- 13.6. Энэ дүрмийн 13.3, 13.4-т заасан анхан болон дунд шатны нэгжийг Удирдах зөвлөлийн зөвшөөрсөн шийдвэрийн үндсэн дээр эмхлэн байгуулна.
- 13.7. Тухайн аймагт намын анхан шатны нэгж байгуулагдаагүй тохиолдолд Төв нам нь анхан шатны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 13.8. Нийслэлд намын нэгж байгуулагдаагүй тохиолдолд Төв нам нь анхан шатны нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 13.9. Нийслэлийн дүүрэг дэх анхан шатны нэгжийг харьяалах дээд шатны байгууллага нь Төв нам байна.
- 13.10. Намын анхан шатны нэгж нь тухайн аймаг, нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хот, тосгоны хэмжээнд үйл ажиллагаагаа явуулна. Намын гишүүн нь өөрийн оршин суугаа аймаг, нийслэлийн намын гишүүн байна.
- 13.11. Дунд шатны буюу Нийслэлийн намын нэгж байгуулагдаагүй үед дүүрэг дэх намын анхан шатны нэгжийн дээд шатны харьяалах байгууллага нь Төв нам байна.
- 13.12. Намын анхан болон дунд шатны нэгжийн удирдах байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. Намын анхан болон дунд шатны нэгжүүд Удирдах Зөвлөлөөс баталсан журам, стандартыг баримталж ажиллана.

АНХАН ШАТНЫ НЭГЖИЙГ БАЙГУУЛАХ

- 13.13. Аймаг, нийслэлийн дүүрэг, улсын зэрэглэлтэй хот, тосгонд намын гишүүдийн тоо 100 буюу түүнээс дээш болсон тохиолдолд тухайн орон нутгийн гишүүдийн саналыг үндэслэн Удирдах зөвлөл нэгж байгуулах зөвшөөрлийг өгнө. Удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр нэгж байгуулахыг хориглоно.
- 13.14. Намын нэгжийн гишүүдийн тоо 100-гаас дээш тохиолдолд бүх гишүүдийн хурлаас есөн төлөөлөгчийг нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно. Тэдгээр төлөөлөгчид анхан шатны нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Төлөөлөгчид хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд Бага хурал гэнэ.
- 13.15. Намын нэгжийн гишүүдийн тоо 100 буюу түүнээс бага бол бүх гишүүдийн хурлаас таван төлөөлөгчийг нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно. Тэдгээр төлөөлөгчид анхан шатны нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Төлөөлөгчид хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд Бага хурал гэнэ.



- 13.16. Намын нэгжийн гишүүдийн тоо 60-аас доош болсон тохиолдолд Удирдах зөвлөл тухайн нэгжийг татан буулгана.

АНХАН БОЛОН ДУНД ШАТНЫ НЭГЖИЙН БҮРЭН ЭРХ

- 13.17. Намын анхан болон дунд шатны нэгж нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 13.17.1. Намын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
- 13.17.2. Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг мэдээлэх, сурталчлах;
- 13.17.3. Тухайн аймаг, нийслэл, дүүрэг, хот, тосгоны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хүний нөөцийн бодлогын талаарх саналаа гаргах;
- 13.17.4. Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах;
- 13.17.5. Намын гишүүн, чадварлаг боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх;
- 13.17.6. Бүх шатны сонгуульд намаас нэр дэвшигчдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, сонгуулийн сурталчилгааны ажлыг зохион байгуулах.
- 13.18. Тухайн аймаг, нийслэл, дүүрэг, хот, тосгоны бүх гишүүдийн 50 хувиас доошгүй нь оролцож байгаа тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.
- 13.19. Намын анхан болон дунд шатны нэгж нь даргатай байна. Нэгжийн дарга намын анхан шатны байгууллагыг удирдлагаар хангаж, төлөөлөгчдийн хуралдааныг даргална. Нэгжийн төлөөлөгчид хурлаараа даргаар томилуулах төлөөлөгчийг Намын Даргад санал болгоно. Намын дарга нь нэгжийн даргыг томилно.
- 13.20. Намын анхан шатны байгууллага нь дэргэдээ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэгжтэй байж болох бөгөөд түүнийг энэ дүрэмд зааснаар байгуулна.
- 13.21. Намын анхан шатны байгууллага байгуулах талаар энэхүү дүрэмд зааснаас бусад нарийвчилсан харилцааг намын Удирдах зөвлөлөөс баталсан журмаар зохицуулна.

АНХАН ШАТНЫ НЭГЖИЙН ДАРГА, ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ОГЦРУУЛЖ, ЧӨЛӨӨЛӨХ

- 13.22. Намын анхан болон дунд шатны нэгжийн дарга, төлөөлөгчийг дараах үндэслэлээр огцруулна. Үүнд:
- 13.22.1. Энэ дүрмийн 3.15-д зааснаар намын дүрмийг зөрчсөн,
- 13.22.2. Энэ дүрмийн 8.5-д заасан үйлдэл гаргасан,
- 13.22.3. Энэ дүрмийн 8.6.2-т заасан үндэслэлээр,



- 13.23. Намын анхан шатны болон дунд шатны нэгжийн дарга, төлөөлөгчийг дараах үндэслэлээр чөлөөлнө. Үүнд:
- 13.23.1. Энэ дүрмийн 8.7-д зааснаар.
- 13.24. Нэгжийн дарга, төлөөлөгчийг огцруулах саналыг намын ямар ч гишүүн Хяналтын зөвлөлд гаргаж болно. Намын гишүүнээс гаргаж буй огцруулах санал үндэслэлтэй эсэхийг Хяналтын зөвлөл шалгаж шийдвэрлэнэ. Хэрэв Хяналтын зөвлөлөөс нэгжийн дарга, төлөөлөгч нь дүрмийг зөрчсөн болох нь тогтоогдвол Намын дарга огцруулах саналыг Бага хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 13.25. Нэгжийн дарга, төлөөлөгчийг чөлөөлөх үндэслэл үүсвэл Бага хурал шийдвэрлэнэ. Бага хурлын шийдвэрийг Намын дарга батламжилна.
- 13.26. Намын анхан болон дунд шатны нэгж санхүүгийн тайландаа алдаа гаргасан болох нь илэрвэл тухайн нэгж нэн дариу тайланд гарсан алдааг засах үүрэгтэй. Хэрэв санхүүгийн тайлангийн алдааг засаж залруулах талаар хурдан шуурхай, идэвх санаачилгатай ажиллаагүй бол Хяналтын зөвлөлөөс холбогдох гишүүнд сахилгын хэрэг үүсгэн шалгаж шийдвэрлэнэ. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 13.27. Намын анхан болон дунд шатны нэгж санхүүгийн тайландаа алдаа гаргасны улмаас нам төрийн санхүүжилт авах боломжгүй болсон тохиолдолд тухайн нэгжид энэ дүрмийн 12.25-д зааснаар хуваарилах санхүүжилтийг 2 жил хүртэл хугацаагаар хасна. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 13.28. Намын анхан болон дунд шатны нэгж нь хууль болон энэ дүрмийн 12.14-т заасан хориглосон этгээдээс хандив авсан тохиолдолд энэ тухай мэдсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор хандивлагч болон сонгуулийн төв байгууллагад мэдэгдэж, хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлнэ. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*
- 13.29. Намын анхан болон дунд шатны нэгж энэ дүрмийн 13.28-д заасны дагуу хандивыг сонгуулийн төв байгууллагад шилжүүлээгүй тохиолдолд тухайн нэгжид хуваарилах төрийн санхүүжилтийг 2 жил хүртэлх хугацаагаар хасна. Түүнчлэн сонгуулийн төв байгууллагад 2 дахин нэмэгдүүлэн төлсөн хандивыг буруутай гишүүнээр нөхөн төлүүлнэ. Мөн буруутай гишүүнд сахилгын шийтгэл хүлээлгэнэ. */Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/*

НАМЫН БОДЛОГО СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГА

/Энэ гарчгийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

- 13.30. Намын бодлого боловсруулахад зөвлөх, судалгаа хийх, намын гишүүдийг сургаж бэлтгэх, иргэдийн улс төрийн боловсролыг дэмжих үүрэг бүхий бодлогын судалгааны



байгууллага буюу Төвийг намын дэргэд ажиллуулна. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

- 13.31. Бодлого судалгааны төв нь нэг тэргүүн, таван судлаачийн бүрэлдэхүүнтэй байх ба тэднийг Гүйцэтгэх зөвлөлөөс дөрвөн жилийн хугацаатайгаар томилно. Бодлого судалгааны төв нь ажлаа Гүйцэтгэх зөвлөлийн өмнө хариуцна. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 13.32. Бодлого судалгааны төвийн судлаачид нь намын бодлогыг боловсруулах чиглэлийн нэг судлаач, намаас даалгасан аливаа төрлийн судалгааг хийх чиглэлээр хоёр судлаач, иргэд болон намын гишүүдийг сургаж бэлтгэх чиглэлийн хоёр багш-судлаач гэсэн бүрэлдэхүүнтэй байна. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 13.33. Бодлого судалгааны төвийн бүтэц, бүрэлдэхүүн, төсөв, санхүүг нэмэгдүүлэх, өөрчлөх шаардлагатай болсон тохиолдолд Гүйцэтгэх зөвлөлийн саналаар Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэнэ. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 13.34. Бодлого судалгааны төв нь Намын дарга, Удирдах зөвлөл, Гүйцэтгэх зөвлөлөөс даалгасан судалгааг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн хүргүүлж байна. Төвийн дарга нь тухайн жилд хийх сургалт, судалгаа буюу ажлын төлөвлөгөөг гарган Гүйцэтгэх зөвлөлөөр батлуулан ажиллана. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 13.35. Бодлого судалгааны төв нь ашгийн төлөө бус сангийн хэлбэртэй байна. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 13.36. Нийгэм, эдийн засгийн болон бусад салбарын бодлогын асуудлаар зөвлөлдөх, намын бодлого, үйл ажиллагаа нь хүний эрх болон жендэрийн эрх тэгш байдалд нийцэж байгаа эсэхийг үнэлэх зэрэг чиг үүрэгтэй бүтцийн нэгж байгуулах эсэхийг Гүйцэтгэх зөвлөлийн саналаар Удирдах зөвлөл шийдвэрлэнэ. /Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/
- 13.37. Нам нь МУИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох ажлыг зохион байгуулах хороог байгуулахгүй. Энэ зүйлийг 2025.12.14-ний өдрийн Ээлжит бус 01 дүгээр Их хурлаар нэмсэн/

АРВАН ДӨРӨВ. БУСАД АСУУДЛЫН ТАЛААР

- 14.1. Нам нь Удирдах дээд байгууллага, Төлөөллийн төв байгууллага, Гүйцэтгэх төв байгууллагын гарын үсэг зурагдсан аливаа шийдвэрийг баталгаажуулах нэг тэмдэгтэй байна. Намын тэмдэг нь гарын үсгийн болон хууль ёсны шийдвэрийн хүчинтэй



байдлыг баталгаажуулна. Намын тэмдгийг “намын тамга” гэж нэрлэж үйл ажиллагаанд хэрэглэнэ. Намын тамгыг намын Дарга барина.

- 14.2. Намын Дарга огцорсон, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, түдгэлзсэн, түдгэлзүүлсэн тохиолдолд намын тамгыг Удирдах зөвлөлийн дотроос намын даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон гишүүн барина.
- 14.3. Дараагийн намын Дарга сонгогдсоноор намын өмнөх дарга түүнд 24 цагийн дотор намын тамгыг шилжүүлнэ. Хэрэв Удирдах зөвлөл тамгыг барьж байгаа тохиолдолд энэ зүйлд заасан хугацааны дотор намын тамгыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулна.
- 14.5. Аймаг, Нийслэл, нийслэлийн дүүрэг, улсын зэрэглэлтэй хот, тосгоны намын нэгж нь өөрийн тэмдэгтэй байх бөгөөд өдөр тутамдаа “тэмдэг” гэх нэршлээр нэрлэж хэрэглэнэ. Тухайн нэгжийн дарга тэмдгийг барина. Нэгжийн дарга огцорсон, чөлөөлөгдсөн тохиолдолд Бага хурлаас томилогдсон төлөөлөгч тэмдгийг барина.
- 14.6. Намын гишүүн намын тамга болон тэмдгийг нуух, авч зугтаах, эрх бүхий этгээдэд шилжүүлэн өгөхгүй байх зэргээр тамга, тэмдгийг хэрэглэхэд саад учруулсан аливаа үйлдэл, эс үйлдэлд сахилгын хэрэг үүсгэх шууд үндэслэл болно.
- 14.7. Энэхүү дүрэм нь Үүсгэн байгуулах Их хурлаар батлагдсан цаг, минутаас эхлэн хүчин төгөлдөр болно.

ЛИБЕРТАРИ НАМ

—oOo—